ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

2017.07.03 Чойр хот

№	Дунд хугацааны зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин	Дэлгэрэнгүй тайлбар (Хэрэгжээгүй шалтгаан)
НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ							
1	Төсвийн сахилга батыг сайжруулж, үр ашиггүй зардлыг багасган, хэмнэлтийг эрхэмлэнэ.	Төсвийн сахилга бат, санхүүгийн хяналтын үр дүнг сайжруулна.	Холбоотой зөрчил гараагүй байна.	100 хувь	-	УИХурлын “Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 47 дугаар тогтоол, Засгийн газрын 2014 оны “Төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” 147 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2017 оны “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх тухай” 01 дүгээр албан даалгавар гарган, хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. Төсвийн байгууллагууд батлагдсан цалин сан, орон тоондоо багтаан ажлын ачааллыг нягтруулан ажиллаж, урсгал засварыг батлагдсан төсөвтөө багтаан гүйцэтгэж байна. Мөн орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийн байгууллагуудын батлагдсан төсвийн зарцуулалтанд хяналт тавьж, төсвийн ил тод нээлттэй байдлыг хангах хүрээнд Шилэн дансны тухай хуулийн дагуу тухайн жилийн төсөв, төсвийн гүйцэтгэл, аудитын дүгнэлт, төсвийн хэмнэлт, хэтрэлт түүний шалтгааны тайлбар, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт зэрэг тогтмол мэдээллийг ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэн, www.shilendans.gov.mn цахим сайтад сар бүр	

						байршуулж, хуулийн хугацаанд мэдээлж ажилласан. Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр төсөв, санхүүгийн ил тод байдлын самбарт байршуулан, төсөв хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, тэвчиж болох зардлуудыг хэмнэж ажилласнаар 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар батлагдсан нийт төсөв 6,820,391.0 мян.төгрөг, гүйцэтгэл 6,613,129.1 мян.төгрөг зарцуулж, 207,261.9 мян.төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй байна. 2017 оны эхний хагас жилд Баянтал сумын Засаг даргын Тамгын газар, Цөм сүргийн үржлийн төв, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, Нийгмийн даатгалын сангууд, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, халамжийн сан зэрэг 7 байгууллагад санхүүгийн хяналт, шалгалт хийн нийт 47,664.7 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 10,052.9 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн акт тогтоож, барагдуулах арга хэмжээ авч байна. Төсвийн гүйцэтгэлийн ил тод байдлыг ханган ажиллаагүй, шилэн дансанд хугацаанд нь мэдээллээ байршуулаагүй Баянтал сумын ЗДТГазарт албан шаардлага хүргүүлж, Шивээговь сумын ЗДТГазрын Санхүүгийн албаны дарга, нягтлан бодогч нарт сахилгын шийтгэл ногдуулсан. 2017 оны 05 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд “Шинэ үеийн эд хариуцагч”-ийн сургалт зохион байгуулж 41 эд хариуцагч 2 өдрийн сургалтанд хамрагдан, сертификат авсан.	
		Хэрэгжилт 70 хувь					
2		Орон нутгийн хөгжлийн санг иргэдэд ил тод, нээлттэй болгож, зарцуулалтын үр дүнг	ОНХС-аар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын	53 хувь	-	Сангийн сайдын 2012 оны “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам батлах тухай” 244 дүгээр тушаалын дагуу ОНХСангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх	

		дээшлүүлнэ.	ажлын санал авахад оролцсон нийт өрхийн эзлэх хувь			хөрөнгө оруулалт, хөтөлбөр төслийн саналыг Шивээговь сумын 583 өрх буюу нийт өрхийн 55.6 хувиас, Сүмбэр сумын 1100 өрх буюу нийт өрхийн 29.3 хувиас, Баянтал сумын 182 өрх буюу нийт өрхийн 47.0 хувиас тус тус авч, саналыг нэгтгэж байна. Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны явцын мэдээллийг тухай бүр www.tender.gov.mn, www.govisumber.gov.mn болон www.haaa.gov.mn цахим хуудас, “Монголын мэдээ”, Үнэн сонинд байршуулж байна. Аймгийн Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд 2017 онд 34 худалдан авалт зохион байгуулахаар төлөвлөснөөс 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 31 тендер шалгаруулалтыг зарлаж, үүнээс 10 буюу 32.3 хувийг цахимаар зарлаж, 22 ажлын гэрээ байгуулагдсан. 2017 оны хагас жилийн байдлаар Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж Улсын комиссоор ашиглалтад хүлээн авсан 1,109,985,085 төгрөгийн өртөг бүхий Шивээговь сумын Эрүүл мэндийн төвийн барилгыг Шивээговь сумын Эрүүл мэндийн төвд, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн хөрөнгөөр хийгдсэн 5,158.488 төгрөгийн өртөг бүхий 8 ширхэг хурд сааруулагч, 58 ширхэг замын тусгаарлагч товруу, 8 ширхэг мэдээлэх тэмдгийг “Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-т, төсвийн 612,000 төгрөгийн хөрөнгөөр худалдан авсан 26 нэр төрлийн 128 ширхэг, хандивын 215,000 төгрөгийн хөрөнгөөр худалдан авсан 4 нэр төрлийн 24 ширхэг номыг Нийтийн номын сангийн данс бүртгэлд бүртгүүлсэн.	
		Хэрэгжилт 70 хувь					
3		Татвар төлөгчдийн хүрээг өргөжүүлэн, татварын	Улсын болон орон нутгийн	100 хувь	-	**Татвар төлөгчдийн хүрээг тодорхой хувиар нэмэгдүүлэх талаар:** Татварын	

		орлогыг нэмэгдүүлж, улс, орон нутгийн татварын орлогыг бүрдүүлнэ.	татварын орлогын төлөвлөгөөний биелэлт			ерөнхий газрын даргын 2017 оны А/13 дугаар тушаалаар 2017 оны татварын албаны үйл ажиллагааны зорилтыг батлан, “Татвар төлөгчдийн бүртгэлийг сайжруулж, хуулийн хэрэгжилтийг хангах жил” болгон зарлаж, татвар төлөгчдийн хүрээг өргөжүүлэхэд онцгой анхааран ажиллаж байна. Аймгийн Засаг даргын 2017 оны А/77 дугаар захирамжаар аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх, татварын бааз суурийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, газар эзэмших, ашиглах, түрээслэх зэргээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжүүдийг татвар төлөгчөөр бүртгэн, татварт хамруулах ажлыг зохион байгуулав. Сүмбэр сумын 1 дүгээр багийн, Төмөр замын баруун талд газар эзэмшиж, ашиглаж байгаа 9 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай танилцаж, Хэрлэн энерго ХХК, Дашваанжил ХХК-ийг салбараар, Эм Ди Эф И ХХК-ны үл хөдлөх эд хөрөнгийг тус тус орон нутагт бүртгэсэн. 2017 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар ХК 1, ХХК 255, ББН 5, ЗБН 10, Хоршоо 24, ОНӨҮГ 5, Салбар-75, Төлөөлөгчийн газар-1, ОНБ 15, төсөвт болон бусад байгууллага-162 буюу нийт хуулийн этгээдийн тоо 528 болж, татварын бааз суурь 41 ААН-ээр нэмэгдсэн.. **Улс орон нутгийн татварын орлогын бүрдүүлэлтийн талаар:** 2017.06.30-ны өдрийн байдлаар Улсын төсвийн орлогын төлөвлөгөө 794,548.0 мянган төгрөг, гүйцэтгэл 1,678.895.0 мянган төгрөг, биелэлт 211.3 хувьтай, Аймгийн төсвийн орлогын төлөвлөгөө 2,250.494.4 мянган төгрөг, гүйцэтгэл 2,750.776.4 мянган төгрөг, биелэлт 109.1 хувь байна.	
	Хэрэгжилт 70 хувь						
4	Бизнесийн	Тусгай зөвшөөрлийг	Хуулийн	100 хувь	-	Бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлэх	

	таатай орчин бүрдүүлж, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг бодлогоор дэмжинэ.	хуулийн хүрээнд хүнд сурталгүй олгож, хяналт шалгалтын давхардлыг багасгана.	шаардлага хангасан аж ахуйн нэгжүүдэд олгосон зөвшөөрөл			зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагуудад хийх хяналт, шалгалтын тоог бууруулах зорилгоор байгууллага тус бүрээс зохион байгуулдаг хяналт, шалгалтыг нэгтгэн, аймгийн Засаг даргын захирамжаар нэгдсэн ажлын хэсэг томилон, зөвлөн туслах чиглэлийг баримталж, хяналт, шалгалтыг зохион байгуулж байна. Аймгийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/137 дугаар захирамжаар архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх ажлыг эхлүүлээд байна. Сүмбэр сумын хэмжээнд тамхины тусгай зөвшөөрөлтэй 15, Шивээговь суманд 9, Баянтал суманд 6 аж ахуй нэгж үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд Цагдаагийн байгууллагатай хамтран тамхины хяналтын тухай хуулийн дагуу удаа эргүүл, шалгалтын ажлыг сум тус бүрт 2 удаа зохион байгуулсан. Архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг холбогдох хууль, журмын дагуу шаардлага хангасан 2 аж ахуйн нэгжид шинээр олгож, 2 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг сунгасан. Сургуулийн өмнөх боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 2 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг сунгаж, шинээр 1 аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрөл олголоо. Эрүүл мэндийн чиглэлээр 5 эмнэлэг, 9 эмийн сан ажиллаж байгаагаас 2017 онд шинээр 1 аж ахуйн нэгжид эмийн сан эрхлэх тусгай зөвшөөрлийг хуулийн дагуу олгоод байна.	
		Хэрэгжилт 40 хувь					
5		Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрийг	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	100 хувь	АОНХС 25.0	Аймгийн Засаг даргын 2017 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/39 дүгээр захирамжаар Жижиг, дунд үйлдвэрлэл,	

		хэрэгжүүлнэ.				үйлчилгээг хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрийн төлөвлөгөөг батлан, 2017 оны хагас жилийн байдлаар 35 арга хэмжээ төлөвлөснөөс 2 арга хэмжээ 100 хувь, 4 арга хэмжээ 70 хувь, 17 арга хэмжээ 40 хувь, 12 арга хэмжээ хэрэгжих шатанд, дундаж хэрэгжилт 51.4 хувьтай байна. Төлөвлөгөөний дагуу “Элбэг, дэлбэг цагаан сар-2017” үзэсгэлэн худалдааг 02 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд зохион байгуулсан. Уг үзэсгэлэн худалдаанд орон нутгийн 73, Улаанбаатар хотын 4, Архангай аймгийн 4 иргэн нийт 81 иргэн, ААНэгж, 80 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 40.3 сая төгрөгийн борлуулалт хийсэн нь өнгөрсөн оноос оролцогчдын тоо 4, борлуулалтын орлого 10.8 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Аймгийн нутаг дэвсгэрт жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг аймгийн Засаг даргын 2017 оны А/149 дүгээр захирамжаар батлуулан мөрдөж эхэллээ. Оны шилдэг бизнес эрхлэгч шалгаруулах журмыг мэргэжлийн холбоодтой хамтран боловсруулж байна. Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих зорилгоор орон сууцны техникийн давхарт үйлчилгээ эрхлэх иргэдийг дэмжин ажиллаж байна. Намрын үзэсгэлэн худалдаа, бизнес эрхлэгчдийн зөвлөгөөн, хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтыг 8, 9, 10 дугаар сард хийхээр төлөвлөсөн.	
		Хэрэгжилт 40 хувь					
6		ЖДҮДС, СХС-ийн зээлийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.	Бий болсон байнгын ажлын байрны тоо Хуваарийн дагуу	50 100 хувь	ЖДҮДС СХС	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн зээлийн эргэн төлөлт хуваарийн дагуу хийгдэж, 2017 оны 06 дугаар сарын 30–ны өдрийн байдлаар зээлийн үлдэгдэл Хас банкинд 311.9 сая төгрөг, Хаан банкинд 9.2	

			төлөгдсөн эргэн төлөлтийн хувь			сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. Сүмбэр сум 2011-2016 онд 110 иргэнд 1,049.6 мянган төгрөгийн зээл олгосон. 2017 оны эхний хагас жилийн байдлаар нийт 931.0 сая төгрөгийн эргэн төлөлтөөс 72.5 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлтийг бүрдүүлж 858.4 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Шивээговь сум 2011-2016 онд 52 иргэнд 332.8 сая төгрөгийн зээл олгосон. 2017 оны эхний хагас жилийн байдлаар 160.8 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Баянтал сум 2011-2016 онд 39 иргэнд 194.1 сая төгрөгийн зээл олгосон. 2017 оны эхний хагас жилийн байдлаар 164.8 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Зээл олгогдож эхэлсэн 2009 оноос хойш Сүмбэр суманд байнгын 135 ажлын байр, улирлын чанартай ажлын байр 32, Шивээговь суманд 86 байнгын ажлын байр, 8 түр ажлын байр, Баянтал суманд 12 байнгын , 14 түр ажлын байр, Хас банкнаас зээл авсан иргэн ААНэгжүүдээс 44 байнгын ажлын байр бий болж, нийт 233 иргэн байнгын ажлын байраар, 54 иргэн түр ажлын байраар хангагдсан байна.	
		Хэрэгжилт 40 хувь					
ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ							
2.1. Худалдаа, үйлчилгээний салбар							
7	Худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.	Орон нутгийн худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж, сургалтанд хамруулан, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллана.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1-ээс доошгүй	Хөтөлбөр	Аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхим, Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо, Хоршоологчдын холбоодтой хамтран ажиллаж байна. Дорноговь аймгийн Стандарчилал хэмжил зүйн хэлтэстэй хамтарч 2017 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр тусгай зөвшөөрөлтэй 34 аж ахуйн нэгжид стандартчилал, хэмжил зүйн	

						талаар сургалт зохион байгуулсан. Мэргэжлийн хяналтын газраас “Хүнсний худалдаа үйлчилгээнд тавигдах шаардлага, түүнд тавих дотоод хяналт”, “Органик хүнсний үйлдвэрлэлд тавигдах шаардлага, түргэн гэмтэх бүтээгдэхүүний хадгалалтын горим”, “Нийтийн хоолны газруудад мөрдөх дүрэм журам”, “Транс тосны хэрэглээ, чанар аюулгүй байдал”ын талаар 4 удаагийн сургалт зохион байгуулж 34 аж ахуйн нэгжийн 62 ажилтныг хамруулсан. Хүнс, хөдөө аж ахуйн газраас “Органик хүнсний тухай хууль”-ийг дагалдан гарах 7 журам, 1 аргачлалын төсөлд санал өгөх хэлэлцүүлгийг зохион байгуулж, 13 иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөл, сумдын Мал эмнэлэг, үржлийн тасгийн газар тариалан, мал аж ахуй, эрүүл ахуйн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг хамруулсан.	
		Хэрэгжилт 100 хувь					
8		Орон сууцны техникийн давхрыг засварлан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг ажлын байраар хангахыг бодлогоор дэмжин, хамтарч ажиллана.	Ажлын байртай болсон үйлдвэрлэл үйлчилгээний тоо	5-аас доошгүй	Хөтөлбөр	Үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх боломжоор ханган 4128 м^2 талбайтай, 3 орон сууцны техникийн давхрыг засварласан. Орон сууцны техникийн давхарт үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэдийг бүртгэхээр аймгийн телевиз, нүүр хуудсаар зар тавиад байна. Одоогоор 5 дугаар байрны орон сууцны техникийн давхарт Ойн анги “Био ялзмаг” үйлдвэрлэх үйл ажиллагаа, АА-ийн сургалт, 2 иргэн биллиард, теннисний клубын үйл ажиллагаа тус тус явуулж байна.	
		Хэрэгжилт 40 хувь					
2.2. Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн салбар							
9	Хүнсний үйлдвэрлэлийг дэмжиж, хүнсний аюулгүй байдлыг хангана.	Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэр, цех байгуулах үүсгэл санаачлагыг бодлогоор дэмжинэ.	Хөнгөлөлттэй зээл авсан үйлдвэр, цехийн тоо	1-ээс доошгүй	СХС, ЖДҮДС 30.0	Засаг даргын 2017 оны А/149 дүгээр захирамжаар Аймгийн нутаг дэвсгэрт жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг батлуулсан бөгөөд тус тэргүүлэх чиглэлд хүнсний бүтээгдэхүүний үйлдвэр, цех байгуулахыг дэмжихээр тусгасан.	

						2017 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар ЖДҮДС-ийн санхүүжилт олгогдоогүй байна. ХХААХҮЯаманд мах боловсруулах, сүү боловсруулах, арьс боловсруулах чиглэлээр тус бүр 1 цех байгуулахаар төсөл хүргүүлсэн боловч одоогоор тодорхой хариу ирээгүй байна.	
		Хэрэгжилт 0 хувь					
10		Стандартын шаардлага хангасан зоорь, агуулахын тоог нэмэгдүүлнэ.	Шинээр ашиглалтанд орох агуулах, зоорийн тоо /ногоо эсвэл мах/ Агуулахаас зах зээлд нийлүүлэх махны хэмжээ Агуулахаас зах зээлд нийлүүлэх төмс, хүнсний ногооны хэмжээ	1-ээс доошгүй 142.6 тн 50.0 тн	СХС, ЖДҮДС 50.0	Аймгийн хэмжээнд байгаа 19 зоорь, 6 агуулахыг стандартад нийцүүлэх, мэдээллийн сан үүсгэх арга хэмжээ авахаар аж ахуйн нэгжийн зоорь, агуулахад шалгалт хийж, дүгнэлт гаргах ажлыг эхлүүллээ. Үүнээс махны 325 тонны багтаамжтай 9 зоорь ашиглагдаж байна. Нэг иргэн 38 тн мах нөөцлөн зах зээлд үе шаттайгаар нийлүүлж 36 тн мах, Шивээ Сервис ХХК нь 8 тн мах нөөцөлж 6.8 тн мах тус тус борлуулсан. Мөн 150 гаруй тн төмс, хүнсний ногоог түр хадгалан зах зээлд борлуулаад байна.	
		Хэрэгжилт 40 хувь					
11		Мал нядалгааны цех байгуулахыг бодлогоор дэмжинэ.	Зээлийн эсвэл газрын бодлогоор дэмжсэн махны нядалгааны цехийн тоо	1-ээс доошгүй	ОНХС, ЖДҮДС, СХС	Аймгийн нутаг дэвсгэрт жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг аймгийн Засаг даргын 2017 оны А/149 дүгээр захирамжаар батлуулсан. Тус тэргүүлэх чиглэлд мал нядалгааны цех, мах боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар тусгасан. Мал нядалгааны цех байгуулах санал санаачлага гаргасан 2 иргэн, 1 ААН-ийг ЭМАА-н бүсэд газар олгон, төсөл, хөтөлбөрийн зээлд хамруулахаар төлөвлөн ажиллаж байна. Шивээговь суманд мал нядалгааны 1 цэг үйл ажиллагаа явуулж, 2017 оны эхний хагас жилд 50 тн мах бэлтгэн зах зээлд борлуулаад байна.	
		Хэрэгжилт 70 хувь					

12		Хүнсний бүтээгдэхүүний шинжилгээнд тавих хяналтыг сайжруулна.	Төлөвлөгөөт шалгалтын тоо	Улиралд 1-ээс доошгүй	ОНТ	Мэргэжлийн хяналтын газраас төлөвлөгөөт 1 шалгалт, урьдчилан сэргийлэх 3 хяналтын явцад нян судлалын лабораторид 71 хүнсний бүтээгдэхүүнийг 226 үзүүлэлтээр шинжлүүлснээс 4 буюу 5.6 хувь нь эерэг гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал дээжийн тоо 2 дахин өссөн, эерэг сорьц 4-өөр нэмэгдсэн, химийн лабораторид 158 хүнсний бүтээгдэхүүнийг 706 үзүүлэлтээр шинжлүүлснээс 13 сорьц эерэг үзүүлэлттэй гарсан нь сорьцын тоо 18 хувиар өссөн, эерэг сорьц 13-аар нэмэгдсэн байна. Эерэг сорьц нэмэгдсэн шалтгаан нь шинжилгээнд хамруулсан дээжийн тоо өссөнтэй холбоотой. Малаас гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний ажил үйлчилгээ эрхлэгчдэд тавих хяналтыг Сүмбэр суманд МЭАЦЛ, Шивээговь, Баянтал сумдад МЭҮТ, МЭН хариуцан гүйцэтгэж байна. МЭАЦ-ийн хяналт шалгалтыг долоо хоног бүр тогтмол хийж хэвшсэн. 2017 оны эхний хагас жилийн байдлаар 10 аж ахуйн нэгж, 88 иргэн үзлэг шалгалтанд хамрагдаж 5105 кг мах, 16995 л сүү, 190 ш арьс шир, 530 кг ноолуур, 465 ширхэг өндгийг тус тус баталгаажуулсан.	
		Хэрэгжилт 70 хувь					
13	Бэлчээрийн мал аж ахуйг эрсдлээс хамгаалж, үүлдэр, угсааг сайжруулж, ашиг шимийг дээшлүүлнэ.	Мал үржлийн нэгжийг байгуулна.	Байгуулсан мал үржлийн нэгжийн тоо	1	ОНТ 6.2	“Сүмбэр зоо” ХХК нь мал үржлийн чиглэлээр Сүмбэр сумын Засаг даргатай гэрээ байгуулж, үйл ажиллагаагаа эхлүүлсэн.	
		Хэрэгжилт 100 хувь					
14		Ямааг ноолуур, махны чиглэлээр, хонь, үхрийг махны чиглэлээр үржүүлж, ашиг шимийг дээшлүүлэх зорилгоор сайн чанарын хээлтүүлэгчээр сайжруулах ажлыг бодлогоор дэмжинэ.	Зээлийн бодлогоор дэмжсэн байна. Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл	100 хувь	СХС 16.1	Аймгийн хэмжээнд нийт 141 бух байгаагаас мах сүүний чиглэлийн 64 бух, нийт 1060 хуц байгаагаас махны чиглэлийн 65 хуц, нийт 856 ухна байгаагаас ноолуурын чиглэлийн 41 ухныг үржилд сайжруулагчаар ашиглаж байна. Мөн каракуль үүлдрийн 26 хуц байна.	
		Хэрэгжилт 40 хувь					

15		Бэлчээрийн менежментийг хэрэгжүүлж, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор бэлчээрийн худаг засварлах, шинээр гаргах, хортон мэрэгчидтэй тэмцэх, нөхөн сэргээх үйл ажиллагааг зохион байгуулна.	Шинээр гаргах инженерийн хийцтэй худгийн тоо Засварлах худгийн тоо Хортон мэрэгчидтэй тэмцэх талбайн хэмжээ. Олон наст ургамал тариалах талбайн хэмжээ	2 1 15000 га 10 га	Сумдын ОНХС 57.5	Хүнс, хөдөө аж ахуйн Сайдын багцаас мал аж ахуйн зориулалтаар 3 худаг гаргахаар шийдвэрлэсэн. БХНСАХЗ-ын 30.0 сая төгрөгөөр Эрчимжсэн аж ахуйн бүсэд инженерийн хийцтэй худаг гаргах ажил 100 хувь хийгдэж улсын комисс байнгын ашиглалтанд хүлээж авсан. Тандалт судалгаагаар аймгийн хэмжээнд нийт 21000 га талбайд хортон мэрэгчтэй тэмцэх хэмжээнд хүрснийг тодорхойлсон. 2017 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар Сүмбэр сумын 4-р багийн нутаг дэвсгэрийн 3000 га талбайд, 5-р багт 4000 га, 6-р багийн 9000 га талбайд энгийн механик аргаар хортон мэрэгчтэй тэмцэх арга хэмжээг зохион байгуулаад байна. Сүмбэр сумын 1 иргэн 0.23 га, Баянтал сумын 1 иргэн 2 га, Шивээговь сумын 1 иргэн 2 га, бүгд 4.23 га талбайд малын тэжээлийн ургамал, царгас тариалах ажлыг эхлүүлсэн.	
		Хэрэгжилт 70 хувь					
16		Малчдыг малжуулах төслийг үргэлжлүүлнэ.	Малжуулсан өрхийн тоо Малын тоо	10 300	-	Малжуулах төсөл, хөтөлбөрт 27.0 сая төгрөг батлагдсан. Үүнээс 5 малчин өрхөд 25.0 сая төгрөгөөр мал худалдан авч өгөхөөр Сүмбэр сумын 6, Шивээговь сумын 3, Баянтал сумын 3 малчин өрхийн нийт 12 төсөл хүлээн авч, сонгон шалгаруулалт хийгдэж байна. Сумдын хэмжээнд малжуулах хөтөлбөрийн хүрээнд Сүмбэр сумын 10 өрхөд 300 бог, Шивээговь сумын 4 өрхөд 224 бог мал олгохоор төлөвлөсөн. Малжуулах төслийн хүрээнд Сүмбэр суманд 300, Шивээговь суманд 208, нийт 508 мал үндсэн эргэлтэнд байна. Баянтал сум энэ оноос малжуулах төслийг хэрэгжүүлж эхлүүлэхээр төлөвлөөд байна.	
		Хэрэгжилт 40 хувь					
17	Эрчимжсэн аж ахуйг дэмжиж, бүтээгдэхүүн	“Сүмбэр” үүлдрийн хонины удмын санг хамгаалах зорилгоор Каракуль	Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл	100 хувь	УТХО 60 .0	Цөм сүргийн үржлийн төвийн Сүмбэр үүлдрийн хонины тоо толгой 2874 ба үүнээс каракуль үүлдрийн хонин тоо толгой 2272	

	үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	үүлдрийн хуцыг үржилд ашиглах, эсвэл гүн хөлдөөсөн үрээр хээлтүүлэг хийнэ.				хүрээд байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд Каракуль хонины үржлийн аж ахуй байгуулах төсөл хүргүүлэн, 600.0 сая төгрөгийг шийдвэрлүүллээ. Уг төслийн хүрээнд гадаадаас 300 толгой каракуль хонь худалдан авахаар болсон.	
		Хэрэгжилт 40 хувь					
18		Гахай, тахианы аж ахуй эрхлэгчдийг эрчимжсэн аж ахуйн бүсэд төвлөрүүлнэ.	Эрчимжсэн аж ахуйн бүсэд газар олгогдсон иргэн, аж ахуй нэгжийг шилжүүлэх тоо	10-аас доошгүй	-	Аймгийн Засаг даргын 2017 оны А/115 дугаар захирамжаар эрчимжсэн мал аж ахуйн бүс нутагт газар олгохтой холбогдох арга хэмжээг эрчимжүүлж, гахай, тахиатай аж ахуй нэгж, иргэнийг бүс нутагт төвлөрүүлэн суурьшуулах ажлыг эхлүүлсэн. Үүний хүрээнд эхний ээлжинд Сүмбэр суманд газар олгосон 11 иргэн, аж ахуйн нэгжийг нэн түрүүнд гаргах мэдэгдэл хүргүүлж, гэрээний шаардлага биелүүлээгүй аж ахуйн нэгжийн газрыг цуцлах арга хэмжээ авах, эрчимжсэн аж ахуйн нэгжийн нутаг дэвсгэрт мөрдөгдөх журмыг шинэчлэн боловсруулж байна. Аймгийн хэмжээнд 24 иргэн, 2 аж ахуйн нэгж 274 гахайтай, 8 иргэн, 1 аж ахуйн нэгж 3619 тахиатай үйл ажиллагаа явуулж байгаагаас “Баялаг эмээлт” тахианы эх сүргийн аж ахуй 3410 тахиатай үйл ажиллагаагаа явуулж байна.	
		Хэрэгжилт 40 хувь					
19		Эрчимжсэн аж ахуйн бүс нутагт инженерийн хийцтэй худаг гаргана.	Шинээр гаргах худгийн тоо	1	УТХО 20.0	БХНСАХЗ-ын 30.0 сая төгрөгөөр Эрчимжсэн аж ахуйн бүсэд инженерийн хийцтэй худаг гаргах ажил 100 хувь хийгдэж, улсын комисс байнгын ашиглалтанд хүлээж авсан.	
		Хэрэгжилт 100 хувь					
20	Мал эмнэлгийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, малын халдварт болон халдварт бус өвчнөөс	Мал эмнэлгийн лабораторийн барилгыг шийдвэрлэнэ.	Барилгын тоо	1	ОНТ	**Хугацаа болоогүй.**	Төсөв хөрөнгө нь шийдвэрлэгдээгүй.
		Үнэлэх боломжгүй.					
21		Мал, амьтны ужиг халдварт өвчнөөс	Вакцинжуулалтанд хамрагдах	97.0 мян.толго	ОНТ 17.0	2017 онд орон нутгийн шинжтэй 12 төрлийн ужиг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх	

	урьдчилан сэргийлнэ.	урьдчилан сэргийлэх арга хэмжээг технологийн дагуу хэрэгжүүлнэ.	малын тоо Шинжилгээнд хамрагдах малын тоо	й 7.2 мян.толгой		вакцинжуулалтын ажлыг 2017 оны 03 дугаар сараас 10 дугаар сарын хооронд хийхээс 2017 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар давхардсан тоогоор 97.0 мян тол мал, амьтан хамруулахаас 51.8 мян.тол хамрагдаж, гүйцэтгэл 53 хувьтай байна. Ужиг халдварт өвчний эсрэг дархлаажуулалтыг өвчний гаргалт, хөдлөл зүйтэй уялдуулан эпозоотологийг судалгаанд үндэслэн зохион байгуулснаар 2017 оны 06 сарын 30-ны өдрийн байдлаар малын өвчлөл, хорогдол гараагүй. Лабораторийн оношилгоо шинжилгээнд технологит хугацааны дагуу хагас жилийн байдлаар 150 толгой мал хамруулахаас 126 толгой мал хамруулж гүйцэтгэл 84.0 хувьтай байна. 2017 онд нийт 7.2 мян.толгой малыг оношилгоо, шинжилгээнд хамруулахаар төлөвлөсөн.	
		Хэрэгжилт 40 хувь					
22		Шинээр гарч байгаа халдварт өвчний тандалт, судалгааг хийх ажлыг эхлүүлнэ.	Тандалт судалгаа хийх газрын тоо	Тандалт судалгаа хийх шаардлагатай газрууды г бүрэн тогтоосон байна.	-	Малын өвчлөлийн эпизоотологийн судалгааг үндэслэн тандалт судалгааг Сүмбэр сумын 5-р багийн нутаг дэвсгэрт хийж эхлээд байна. Тандалт судалгаанд Сүмбэр сумын 4, 5 дугаар багийн 38 малчин өрхийн 28558 толгой мал, сүргийг хамруулж, үүнээс 15 мал өвчилсөн байсныг эрүүлжүүлсэн. Мөн 4853м^2 талбай бүхий хашаа хороонд ариутгал хийж, 12 төрлийн 342 ш гарын авлага тараасан.	
		Хэрэгжилт 70 хувь					
23		Мал эмнэлгийн нэгжүүдийг дэмжиж, малын эм тарианы зохистой хэрэглээг нэвтрүүлж, хяналт тавина.	Малчдад зохион байгуулах сургалтын тоо Зах зээлд борлуулагдаж буй малын гаралтай бүтээгдэхүүний чанарын хяналт	1-ээс доошгүй 100%	-	Монгол ВИ.И.ТИ.НЕТ төрийн бус байгууллагатай хамтран “Малын эмийн зохистой хэрэглээ, халдваргүй өвчин” сэдэвт 6 цагийн сургалт зохион байгуулав. Уг сургалтанд 3 сумын 49 малчин, 12 малын эмч нийт 61 хүн хамрагдлаа. Мөн Сүмбэр сумын малчдын зөвлөлгөөн, 4,5,6-р багийн өдөрлөгөөр малын эмийн зохистой хэрэглээний тухай мэдээлэл хүргэн, гарын авлагыг 230 малчин өрхөд олгов.	

						Мал, амьтнаас гаралтай хүнсний бүтээгдэхүүний магадлан шинжилгээг 430 сорьцонд хийхээс 193 сорьцонд хийж, гүйцэтгэл 45 хувьтай байна. Үүнд: Махны 54 сорьцонд шинжилгээ хийж 5813 кг мах, сүү, сүүн бүтээгдэхүүний 9 сорьцонд шинжилгээ хийж 17015 кг сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний 130 сорьцонд шинжилгээ хийж 18480 ш өндгийг тус тус баталгаажууллаа. Мөн боом өвчнийг илрүүлэх шинжилгээнд ноолуурын 8 сорьцыг хамруулж 190 кг ноолуур, арьс ширний 31 сорьцыг хамруулж 190 ш арьс ширийг тус тус баталгаажуулсан.	
		Хэрэгжилт 70 хувь					
24	Газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	Усалгаатай газар тариаланг хөгжүүлж, техник, тоног төхөөрөмжийн хангамжийн хувь, нэгж га-аас авах ургацыг нэмэгдүүлнэ.	Эргэлтийн талбайн хэмжээ Талбайн ашиглалт Нэгж ургацын хэмжээ	73.5 га 70 хувь 65 цн/га	ХЭДС, СХС	Аймгийн хэмжээнд малын тэжээл, төмс, хүнсний ногоо тариалах талбай 76.5 га-д хүрсэн. Үүнээс 2017 онд шинээр 2 га талбай эргэлтэд орж, 2 га талбайг хашаажуулсан байна. Мөн техникийн боломж байхгүй иргэдэд 2 цэгээс бага оврын 6 трактор, дунд оврын 2 трактор, том оврын 1 тракторaар техникийн үйлчилгээ үзүүлж байна.	
		Хэрэгжилт 40 хувь					
25		Хүлэмжийн аж ахуйг дэмжиж, ургацыг нэмэгдүүлнэ.	Шинээр ашиглалтанд оруулах хүлэмжийн хэмжээ	120 м^2	ХЭДС 1.3	Шинээр хүлэмжийн аж ахуй эрхлэх 3 иргэнийг арга зүйн зөвлөгөөгөөр хангасан бөгөөд 96 м^2 хүлэмж шинээр ашиглалтанд орж аймгийн хэмжээнд нийт 1878 м^2 талбай бүхий 33 хүлэмжинд 6 төрлийн ногоо тариалсан байна.	
		Хэрэгжилт 70 хувь					
26		Чацаргана болон бусад жимс, жимсгэнэ тариалахыг дэмжинэ.	Шинээр тариалах талбайн хэмжээ	0.5 га	ХХО 1.4	ХААИС-тай хамтран жимс жимсгэний мод бут тариалах сонирхолтой иргэдэд сургалт зохион байгуулж 52 иргэн хамрагдсан. Жимс жимсгэнэ тариалдаг 3 иргэний талбайд таналт, тайралтын талаар дадлага сургууль хийсэн. Мөн 5 иргэн 0.26 га талбайд 225 ш чацарганы мод тариалсан. Аймгийн хэмжээнд жимст цэцэрлэгийн талбай нийт 14.48 га болж өслөө.	
		Хэрэгжилт 40 хувь					

27	Хөнгөн үйлдвэрлэлийг дэмжиж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	Хөнгөн үйлдвэрлэлийн бүсийн дэд бүтцийн зураг төсөв боловсруулан, газар олголтыг зохион байгуулна.	Зураг төсвийн боловсруулах явцын хувь Газар зохион байгуулалтын хэрэгжилтийн хувь	100 хувь 100 хувь	АОНХС 2.5 ЖДҮДС	Хөнгөн үйлдвэрийн бүсийн газар сонгон шалгаруулалтыг зарлаад байна. Газар сонгон шалгаруулалтын шалгуурт дэд бүтцийн тодорхой хувийг шийдвэрлэхээр тусгасан.	
		Хэрэгжилт 40 хувь					
28		“Итгэлийн зээл” олгож, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжинэ.	Олгосон зээлийн тоо	5-аас доошгүй	ЖДҮДС	Засгийн газраас тодорхой шийдвэр гараагүй байна.	Төсөв хөрөнгө нь шийдвэрлэгдээгүй.
		Үнэлэх боломжгүй.					
29		Цагаан сар, Намрын ногоон өдрүүд үзэсгэлэн худалдаа, Бизнес эрхлэгчдийн зөвлөгөөн зохион байгуулна.	Зохион байгуулах арга хэмжээний тоо	2,4,8-р сард тус бүр 1 удаа зохион байгуулна.	хөтөлбөр	“Элбэг, дэлбэг цагаан сар-2017” үзэсгэлэн худалдааг 02-р сарын 17, 18-ны өдрүүдэд зохион байгууллаа. Уг үзэсгэлэн худалдаанд орон нутгийн 73, Улаанбаатар хотын 4, Архангай аймгийн 4 иргэн, нийт 81 иргэн, ААНэгж, 80 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 40.3 сая төгрөгийн борлуулалт хийсэн нь өнгөрсөн оноос оролцогчдын тоо 4, борлуулалтын орлого 10.8 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Шилмэл мал, шилдэг бүтээгдэхүүн үзэсгэлэн худалдааг 09 дүгээр сард зохион байгуулахаар төлөвлөөд байна.	
		Хэрэгжилт 40 хувь					
2.3. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбар							
30	Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийг дэмжиж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	Шивээ-Овоогийн нүүрсний ордыг түшиглэн хэрэгжүүлэх төслүүдийг бодлогоор дэмжинэ.	Шаардлагатай мэдээ, мэдээллээр хангасан байдал	Шаардлагатай мэдээ, мэдээллээр бүрэн хангаж, хамтран ажилласан байна.	-	Шивээ-Энержи төслийн багийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж, хамтран ажиллаж байна. Одоогоор тус төслийн ТЭЗҮ боловсруулах ажлууд хийгдэж байна.	
		Хэрэгжилт 40 хувь					
31		Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолтын	Олборлолт эхлүүлсэн	1	ХХО	Одоогийн байдлаар түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай	

		ажлыг эхлүүлнэ.	үйлдвэрийн тоо			зөвшөөрөлтэй 1 аж ахуйн нэгж, хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 2 аж ахуйн нэгж байгаа боловч олборлолтын үйл ажиллагаа эхлээгүй байна.	
		Үнэлэх боломжгүй.					
32		Барилгын материалын үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ.	Олгосон зөөл эсвэл газрын тоо	1	ХХО	Аймгийн нутаг дэвсгэрт жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээ хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг 2017 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж А/149 дүгээр захирамжаар батлагдсан. Тус тэргүүлэх чиглэлд барилгын материалын үйлдвэрлэлийг тусгасан. Аймгийн хэмжээнд вакум цонхны үйлдвэр 1, блок, лоткины таг, явган замын хашлага үйлдвэрлэдэг 1 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна.	
		Хэрэгжилт 40 хувь					
2.4. Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, дэд бүтцийн салбар							
33	Газар зохион байгуулалтын менежментийг сайжруулж, газар олголтыг эрчимжүүлнэ.	Иргэнд газар өмчлүүлэх ажлыг эрчимжүүлнэ.	Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө	100 хувь	-	2017 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу Сүмбэр суманд 1558, Баянтал суманд 150, Шивээговь сумынд 100 иргэнд тус тус газар өмчлүүлэхээр төлөвлөснөөс Сүмбэр суманд шинээр газар өмчлүүлэх 1408, эзэмшлийн газрыг өмчлөлд шилжүүлэх 15, Баянтал суманд 150, Шивээговь суманд 62 иргэний өргөдлийг хүлээн авч, хянан шийдвэрлэхээр ажиллаж байна.	
		Хэрэгжилт 70 хувь					
34		Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг тодотгоно.	Судалгааны ажлын явц	Судалгаа г бүрэн хийлгэж, хүлээн авсан байна.	АОНХС 50.0	Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг тодотгох, сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажилд ОНХСангаас 40.0 сая төгрөгийг шийдвэрлэн, тендер шалгаруулалтыг зарлаад байна.	
		Хэрэгжилт 40 хувь					
35		Аймаг, сумдын төвийн нийтийн эзэмшлийн зам, гудамж, талбайн	Тухайн жилийн төлөвлөсөн ажлын гүйцэтгэл	100 хувь	Сумдын ОНХС 10.0	Сүмбэр сумын ОНХСангийн 50.0 сая төгрөг, АОНХСангийн 20.7 сая төгрөгөөр аймгийн төвийн хаягжуулалтын ажлыг хийхээр тендер	

		хаягжуулалтыг үе шаттайгаар хийнэ.				шалгаруулалтыг зарлаад байна.	
		Хэрэгжилт 40 хувь					
36		Газрын биржийн цахим системийг нэвтрүүлж, иргэдэд үйлчилж эхэлнэ.	Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл	100 хувь	-	Газрын биржийн цахим системийг нэвтрүүлж, тус системээр аймгийн хэмжээнд 25 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газрын барьцааг бүртгэн, 7 барьцааг чөлөөлж, үйлчилгээний зориулалттай 1600м^2 газрын дуудлага худалдааг цахим хэлбэрээр 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдөр цахимаар зохион байгуулсан. Шивээговь, Баянтал, Сүмбэр сумдад цахим биржийг нэвтрүүлэн үйл ажиллагааг тогтмолжуулсан.	
		Хэрэгжилт 70 хувь					
37		Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлаж, гэрчилгээг шинэчилж, солих ажлыг эхлүүлнэ.	Тухайн жилийн гүйцэтгэл	100 хувь	-	Лэнд менежер программыг нэвтрүүлж, эзэмшлийн газарт кадастрын хэмжилт хийлгэх хүсэлт гаргасан 4 ААНБ-ын хэмжилтийг хийж, газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлан, гэрчилгээг шинэчилж, солих ажлыг эхлүүллээ.	
		Хэрэгжилт 40 хувь					
38	Хот суурин газрын дэд бүтцийг нэмэгдүүлж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэн, хот тохижилтыг сайжруулна.	Аймаг, сумын төвд цэвэрлэх байгууламж байгуулах зураг төсвийг боловсруулна.	Зураг төсөв боловсруулах ажлын явц	Зураг төсвийг бүрэн хийлгэж, хүлээн авсан байна.	АОНХС 40.0	Аймгийн төвийн цэвэрлэх байгууламж шинээр барих төслийг Барилга хот байгуулалтын яамнаас Унгар улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэхээр Сангийн яам болон Гадаад харилцааны яаманд хүсэлтийг хүргүүлсэн. Шивээговь сумын төвд цэвэрлэх байгууламж байгуулах ажлыг 2018 онд хийхээр төлөвлөн, судалгааны ажил хийгдэж байна.	
		Хэрэгжилт 40 хувь					
39		Сүмбэр сумын 1 дүгээр багийн бохирын шугамыг аймгийн төв цэвэрлэх байгууламжтай холбоно.	Холбох бохирын шугамын урт	3 км	АОНХС 230.0	Улаанбаатар Төмөр Зам ХНН-тэй хамтран гүйцэтгэхээр тендер шалгаруулалт зарлахаар бэлтгэж байна.	
		Хэрэгжилт 0 хувь					
40		1000 айлын орон сууцны хорооллын төслийн гадна	Зураг төсөв боловсруулах	Зураг төсвийг	АОНХС 2.5	Хөрөнгийн эх үүсвэр батлагдаагүй.	Төсөв хөрөнгө нь

		инженерийн шугам сүлжээний ажлын санхүүжилтийг шийдвэрлэж, цахилгаан хангамжийн зураг, төсвийг боловсруулна.	ажлын явц	бүрэн хийлгэж, хүлээн авсан байна.			шийдвэрлэгдээ гүй.
		Үнэлэх боломжгүй.					
41		Сүмбэр сумын 1 дүгээр багийн Төмөр замын хэсгийн айл өрхийг цэвэр бохир ус, 2 дугаар багийн гэр хорооллын айл өрхийг цэвэр усны шугамд холбох ажлын судалгааг хийж, зураг төсвийг боловсруулна.	Зураг төсөв боловсруулах ажлын явц	Зураг төсвийг бүрэн хийлгэж, хүлээн авсан байна.	АОНХС 20.0	Дэлхийн банкны 40.0 сая төгрөгийн хөрөнгөөр Сүмбэр сумын 1, 2 дугаар багийн гэр хорооллын айл өрхийг цэвэр усны шугаманд холбох, 2 дугаар өргөлтийн насос станц байгуулах ажлын зураг төсөв боловсруулах ажлын тендер шалгаруулалтыг зарласан.	
		Хэрэгжилт 40 хувь					
42		Хонхор хотхоны 5-р байрны дээвэр, 1-р байрны гадна фасадыг засварлана.	Гүйцэтгэл	5-р байрны дээвэр, 1-р байрны фасад хийгдсэн байна.	АОНХС 200.0 Сумын ОНХС 55.0	АОНХСангийн 200.0 сая төгрөгөөр Сүмбэр сумын 3 дугаар багийн 1-р байрны гадна фасадыг засварлах ажлын гүйцэтгэгчээр Вилла бридж ХХК-тай гэрээ байгуулан, ажлыг эхлүүлээд байна. Сүмбэр сумын ОНХСангийн 55.0 сая төгрөгөөр 3-р багийн 5-р байрны дээврийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг нээж, гэрээ байгуулах эрх олгосон.	
		Хэрэгжилт 40 хувь					
43		Хонхор хотхоны нийтийн эзэмшлийн орон сууцнуудад барилгын дүгнэлт гаргуулна.	Судалгааны явц	Дүгнэлт гарч, хүлээж авсан байна.	-	Сүмбэр сумын нийтийн эзэмшлийн орон сууцнуудад барилгын дүгнэлт гаргуулах ажлыг гүйцэтгүүлэх хөрөнгийг 2017 оны төсвийн тодотголоор АОНХСанд тусгуулан батлуулсан. 2018 онд төсвийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын зураг төсөв боловсруулах зардлаар гүйцэтгэхээр төлөвлөж байна.	
		Хэрэгжилт 40 хувь					
44		Хонхор хотхоны хөрсний геологийн дүгнэлтийг гаргуулж, ус зайлуулах системийн зураг төсвийг боловсруулна.	Зураг төсөв боловсруулах ажлын явц	Зураг төсвийг бүрэн хийлгэж, хүлээн	-	Хонхор хотхоны хөрсний геологийн дүгнэлтийг гаргуулж, ус зайлуулах системийн зураг төсөв боловсруулах ажлын хөрөнгийг 2017 оны төсвийн тодотголоор АОНХСанд тусгуулан батлуулсан 2018 онд төсвийн	

				авсан байна.		хөрөнгөөр хийгдэх ажлуудын зураг төсөв боловсруулах зардлаар гүйцэтгэхээр төлөвлөж байна.	
		Хэрэгжилт 40 хувь					
45		Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн тоглоомын талбайг засварлан, тохижуулна.	Гүйцэтгэл	Сүмбэр сумын 1,2,3-р багуудын тоглоомын талбайг засварлан, тохижуулна.	АОНХС 230.0	АОНХСангийн 21.0 сая төгрөгөөр Боржигин чуулгын өмнөх талбай, аймгийн үдэлт, угталтын хаалга, Сүмбэр сумын 1, 3 дугаар багуудад хүүхдийн тоглоомын талбай байгуулах зэрэг 11 тохижилтын ажлын зураг төсөв боловсруулах ажил хийгдэж, дуусах шатанд байна. АОНХСангийн 80.0 сая төгрөгөөр Нийтийн эзэмшлийн тоглоомын талбайн тохижилтын ажлын тендер шалгаруулалтыг зарласан.	
		Хэрэгжилт 40 хувь					
46		Аймгийн төвд дугуйн зам байгуулна.	Байгуулагдсан дугуйн замын урт	3000 м	АОНХС 300.0	Аймгийн төвд дугуйн зам байгуулах ажлын зураг, төсөв боловсруулах хөрөнгийг 2017 оны төсвийн тодотголоор АОНХСанд тусгуулан батлуулсан 2018 онд төсвийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын зураг, төсөв боловсруулах зардлаар гүйцэтгэхээр төлөвлөж байна.	
		Хэрэгжилт 40 хувь					
47		Аймгийн соёл, спорт, амралтын хүрээлэнгийн ашиглалтын менежментийг сайжруулан, хувийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ.	Ашиглалтын гэрээ байгуулсан спорт талбайн тоо	6 /хөлбөмбөг, сагсан бөмбөг, софт теннис, хокей, цана чарга, усан оргилуурын талбайн ууд/	-	Аймгийн соёл, спорт, амралтын хүрээлэнгийн менежментийг сайжруулах зорилгоор төсөл сонгон шалгаруулалтыг 2017 оны 05, 06 дугаар саруудад 2 удаа зарласан боловч төсөл ирээгүй тул дахин зарлаад байна.	
		Хэрэгжилт 40 хувь					

48		Сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааг сайжруулна.	СӨХ-той болсон нийтийн эзэмшлийн орон сууцнууд	1-р багийн нийтийн эзэмшлийн орон сууцнууд	-	Сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааг дэмжих зорилгоор “2017 онд аймгийн шилдэг тохижилт, ногоон байгууламж бий болгосон иргэн, ААНБ-ыг шалгаруулах уралдаан” зарласан. Төрийн болон төсөвт байгууллагуудын албан хаагчдын СӨХ-ийн төлбөрийг цалингаас хураах болон өр төлбөрийг барагдуулахаар үүрэг чиглэл өгч ажиллаж байна. Сүмбэр сумын 1 дүгээр багийн нийтийн орон сууцнуудын дунд СӨХ байгуулах ажлыг зохион байгуулахаар ажиллаж байна. АОНХСангийн 28.0 сая төгрөгөөр Сүмбэр сумын 3-р багийн нийтийн орон сууцны орцны саравчны бэхэлгээ, хогийн сав, сандал суурилуулах ажлыг гүйцэтгүүлэхээр тендер шалгаруулалтыг зарлаад байна. Мөн Сүмбэр сумын 3-р багийн нийтийн эзэмшлийн гудамж тайлбайн цэвэрлэгээ арчилгааг Бадрах-70 СӨХ-д хариуцуулан, зам арчилгаа хариуцсан 2 ажилтныг ажиллуулж байна.	
		Хэрэгжилт 40 хувь					
49		Сумдын хог тээвэрлэх машины хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлнэ.	Автомашины тоо	1	Сумдын ОНХС 80.0	Хөрөнгө санхүүжилт батлагдаагүй.	Төсөв хөрөнгө нь шийдвэрлэгдээгүй.
		Үнэлэх боломжгүй.					
50		Сумдын айл өрх, нийтийн эзэмшлийн гудамж талбайг хогийн саваар хангах ажлыг эхлүүлнэ.	Хогийн савны тоо	100	Сумдын ОНХС 25.0	Сумдын айл өрх, нийтийн эзэмшлийн гудамж талбайг хогийн саваар хангах ажилд шаардлагатай 50.0 сая төгрөгийг төсвийн тодотголоор АОНХСанд тусгуулан батлуулж, тендер шалгаруулалтыг зарлаад байна.	
		Хэрэгжилт 40 хувь					
51		Аймгийн төвийн төвлөрсөн хогийн цэгийг хашаажуулж, ландфилл технологийг тогтмолжуулна.	Хашаажуулсан талбайн хэмжээ	20.8 га	Сумын ОНХС 110.0	Аймгийн төвийн төвлөрсөн хогийн цэгийг хашаажуулах ажилд шаардлагатай 50.0 сая төгрөгийг төсвийн тодотголоор АОНХСанд тусгуулан батлуулж, тендер шалгаруулалтыг зарлаад байна.	
		Хэрэгжилт 40 хувь					

52		Аймгийн төвийн усан хангамжийн эх үүсвэрт усны чанар сайжруулах, халдваргүйжүүлэх төхөөрөмж суурилуулна.	Суурилуулсан тоног төхөөрөмжийн тоо	1-ээс доошгүй	ОУБ 120.0	Аймгийн төвийн усан хангамжийн эх үүсвэрт усны чанар сайжруулах, халдваргүйжүүлэх төхөөрөмж суурилуулах ажилд шаардлагатай 120.0 сая төгрөгийг төсвийн тодотголоор АОНХСанд тусгуулан батлуулж, тендер шалгаруулалтыг 2017 оны 07 сард зарлахаар бэлтгэл ажлыг хангаж байна.	
		Хэрэгжилт 40 хувь					
53	Хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан усаар хангана.	Сумдын усан хангамжийн эх үүсвэрийн усан сан, өргөх станцыг өргөтгөх ажлын зураг төсвийг боловсруулна.	Зураг төсөв боловсруулах ажлын явц	Зураг төсвийг бүрэн хийлгэж, хүлээн авсан байна.	АОНХС 15.0	Дэлхийн банкны 40.0 сая төгрөгийн хөрөнгөөр Сүмбэр сумын 1, 2 дугаар багийн гэр хорооллын айл өрхийг цэвэр усны шугамд холбох, 2 дугаар өргөлтийн насос станц байгуулах ажлын зураг, төсөв боловсруулах ажлын тендер шалгаруулалтыг зарлаад байна. Мөн Баянтал сумын усан хангамжийн эх үүсвэрт усан сан байгуулах ажлын зураг төсвийг 2017 оны төсвийн тодотголоор АОНХСанд тусгуулан батлуулсан бөгөөд 2018 онд төсвийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын зураг, төсөв боловсруулах зардлаар гүйцэтгэхээр төлөвлөж байна.	
		Хэрэгжилт 40 хувь					
54		Гэр хорооллын ус түгээх байрыг шинээр барьж, засварлан, ус түгээх авто машинаар хангана.	Шинээр барих, засварлах, тохижуулах байрны тоо Шинээр авсан усны автомашины тоо	3 /Сүмбэр сум/ 1 /Сүмбэр сум/	Сумдын ОНХС 50.0 Сумын ОНХС 150.0	Сүмбэр сумын ус түгээх 2 байрыг засварлах шаардлагатай 30.0 сая төгрөгийг төсвийн тодотголоор АОНХСанд тусгуулан батлуулж, тендер шалгаруулалтыг зарлаад байна. Түшиг ХХК-тай гэрээ байгуулан БХНСАХЗ-ын 90.0 сая төгрөгөөр Усалгаа арчилгааны, ус зөөвөрлөх зориулалтын автомашин худалдан авсан. Мөн Сүмбэр сумын ОНХСангийн 10 сая төгрөгөөр гэр хорооллын ус түгээх байрыг засварлахаар төсөвлөсөн.	
		Хэрэгжилт 70 хувь					

55	Мэдээллийн технологи, харилцаа холбооны хамрах хүрээг өргөтгөж, орон нутагт өндөр хурдны сүлжээг нэвтрүүлж, хэрэглээг нэмэгдүүлнэ.	Баянтал сумыг өндөр хурдны шилэн кабельд холбоно.	Кабель шугамын урт	3 км	Сумын ОНХС 30.0	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Баянтал сумыг өндөр хурдны шилэн кабельд 2017 оны 02 дугаар сард холбосон.	
		Хэрэгжилт 100 хувь					
56	Цахилгаан, дулааны эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлж, хэвийн үйл ажиллагааг хангана.	Сүмбэр сумын 3 дугаар багийн 6 кВт-ын шугамыг зөөвөрлөж, шилжүүлнэ.	Шилжүүлэх шугамын урт	2.3 км	УТХО 150.0	Дэлхийн банкны санхүүжилтээр Говьсүмбэр аймагт хийгдэх эрчим хүчний төслийн хүрээнд уг ажлыг хийлгэхээр төлөвлөсөн. Уг ажлын зураг төсөв боловсруулах ажил хийгдэж байгаа бөгөөд санхүүжилт шийдвэрлэгдээгүй байна.	
		Хэрэгжилт 0 хувь					
57		Сүмбэр сумын өмчлөлд олгосон газруудад 0.4 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам татна.	Шинээр тавьсан шугамын урт	5 км	УТХО 216.5	Дэлхийн банкны санхүүжилтээр Говьсүмбэр аймагт хийгдэх эрчим хүчний төслийн хүрээнд уг ажлыг хийлгэхээр төлөвлөсөн. Уг ажлын зураг төсөв боловсруулах ажил хийгдэж байгаа бөгөөд санхүүжилт шийдвэрлэгдээгүй байна.	
		Хэрэгжилт 0 хувь					
58		Аймгийн төвд дулааны станц барих ажлын ТЭЗҮ, зураг төсөв боловсруулна.	Зураг төсөв боловсруулах ажлын явц	Зураг төсвийг бүрэн хийлгэж, хүлээн авсан байна.	АОНХС 70.0	Солонгос улсын Эксим банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэхээр аймгийн төвд дулааны станц барих ажлын мэдээллийг бэлтгэн, ЭХЯ-нд хүргүүлсэн боловч дулааны станц байгуулах ажил дэмжигдээгүй.	Төсөв хөрөнгө нь шийдвэрлэгдээгүй.
		Үнэлэх боломжгүй.					
59		Аймгийн төвийн уурын зуухны хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	Нэмэгдүүлсэн зуухны хүчин чадал	8.4 мВт	УТХО 600.0	Эрчим хүчний яаманд санал хүргүүлж, 2017 оны 04 дүгээр сарын 08-10-ны өдрүүдэд тус яамнаас ажлын хэсэг ажиллаж, дүгнэлт гаргасны үндсэн дээр Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны “Ус-Ду ОНӨААТҮГ-ын уурын зуухны хүчин чадлыг нэмэгдүүлэх тухай“ 20 дугаар	

						тогтоолын хүрээнд зуухны өргөтгөлийн ажлын зураг, төсөв боловсруулах ажлыг Жигүүрт хөлөг ХХК-тай гэрээ байгуулан, гүйцэтгүүлж байна.	
		Хэрэгжилт 40 хувь					
60		Шивээговь сумын уурын зуухны хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг эхлүүлнэ.	Ажлын явц	Хөрөнгө, санхүүжилтийг шийдвэрлүүлсэн байна.	-	Шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр батлагдаагүй	
		Хэрэгжилт 0 хувь					
61		Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг бий болгож, салхин болон нарны цахилгаан станц байгуулах ажлыг бодлогоор дэмжинэ.	Байгуулагдсан станцын тоо	1	ХХО	Сүмбэр суманд И-Эс-Би Солар Энержи ХХК-д 10 мВт-ын хүчин чадалтай нарны цахилгаан станц байгуулах зориулалтаар 24.6 га, Санстеппе ХХК-д 50 мВт-ын хүчин чадалтай нарны цахилгаан станц байгуулах зориулалтаар 100 га, Айдинер глобал ХХК-д 110 кВт-ын салхин цахилгаан станц байгуулах зориулалтаар 52 га газрыг тус тус олгосон. Айдинер глобал ХХК салхин цахилгаан станц байгуулах ажлын зураг төсөв 2016 онд хийгдэж, барилга угсралтын ажлын санхүүжилтийг шийдвэрлүүлэх, ажлыг эхлүүлэхээр бэлтгэл ажлууд хийгдэж байна. И-Эс-Би Солар Энержи ХХК Хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилтийг шийдвэрлэж, цахилгаан эрчим хүч нийлүүлэх гэрээг Засгийн газартай 2017 оны 03 дугаар сарын 30-ны өдөр байгуулсан бөгөөд ажлыг 2017 оны 09 дүгээр сараас эхлүүлэхээр төлөвлөсөн. Санстеппе ХХК-ний нарны цахилгаан станц барих ажлын хөрөнгө санхүүжилт шийдвэрлэгдэн, ажил эхлэх бэлтгэл хийгдэж байна.	
		Хэрэгжилт 70 хувь					
62		Хийн түлшний хэрэглээг нэмэгдүүлж, хийн түлшний	Байгуулагдсан хийн түлшний	1	ХХО	Гор Газ ХХК нь хийн түлшний түгээх станц байгуулан 2017 оны 02 дугаар сард	

		түгээх станц байгуулахыг бодлогоор дэмжинэ.	түгээх станцын тоо			ашиглалтад оруулсан.	
		Хэрэгжилт 100 хувь					
63		Аймгийн төвд шинээр барих авто замын ажлыг эхлүүлсэн байна.	Ажлын явц	Хөрөнгө, санхүүжилтийг шийдвэрлүүлсэн байна.	-	Аймгийн төвд 370 м авто зам барих ажилд шаардлагатай 140.0 сая төгрөгийг төсвийн тодотголоор АОНХСанд тусгуулан батлуулж, тендер шалгаруулалтыг зарлан, нээлт хийгээд байна. Мөн Авто замын сангийн 20.0 сая төгрөгөөр нийтийн эзэмшлийн талбайн авто замыг өргөтгөх, ажлын тендер шалгаруулалтыг зарлан, шууд гэрээ байгуулах шатанд байна.	
		Хэрэгжилт 40 хувь					
64	Орон нутгийн чанартай авто замын сүлжээг өргөтгөж, засварлана.	Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд гэрэлтүүлэг тавина.	Шинээр тавьсан гэрэлтүүлгийн тоо	29	АОНХС 30 АЗС 12.0	Сүмбэр сумын 1 дүгээр багт АОНХСангийн 30.0 сая төгрөгөөр 24 ширхэг гэрэлтүүлэг суурилуулах ажлын зураг төсвийг гүйцэтгүүлэн, тендер шалгаруулалтыг зохион байгуулж, гэрээ байгуулах шатанд байна. Сүмбэр сумын 3 дугаар багт Хэлмэгдэгсэдийн хөшөөнөөс дөрвөн замын уулзвар хүртэлх авто замын дагуу Авто замын сангийн 11.6 сая төгрөгөөр 9 гэрэлтүүлэг суурилуулахаар Сүмбэр Старлет ХХК-тай гэрээ байгуулж, ажлыг эхлүүллээ.	
		Хэрэгжилт 40 хувь					
65		Нийтийн эзэмшлийн авто замыг засварлаж, шинээр зогсоол байгуулна.	Засварласан авто замын хэмжээ Шинээр тавьсан зогсоолын хэмжээ	600 м2-аас багагүй 450 м2-аас багагүй	АЗС 35.0	Авто замын сангийн 35.0 сая төгрөгөөр нийтийн эзэмшлийн талбайн авто замыг өргөтгөх, зогсоол байгуулах ажлуудын тендер шалгаруулалтыг зарлаж амжилтгүй болсон тул шууд гэрээ байгуулах шатанд байна.	
		Хэрэгжилт 40 хувь					
66		Тохижилт үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ОНӨААТҮГ-уудыг бэхжүүлж, зам засвар арчлалт хийх тоног төхөөрөмжөөр хангана.	Авто замын зүсэгч, индүү Цас хусагчийн тоо	Тус бүр 1 ш 5 ш	ОНТ 12.0	Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГазрыг Авто замын сангийн 12.0 сая төгрөгөөр авто замын зүсэгч, индүү, цас хусагчаар хангасан.	
		Хэрэгжилт 100 хувь					
ГУРАВ. НИЙГМИЙН БОДЛОГО							

3.1. Эрүүл мэндийн салбар							
67	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх тогтолцоог сайжруулан, оношилгоо үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	100 хувь	АОНХС 10.0	Дэд хөтөлбөрийн хүрээнд 8 арга хэмжээг төлөвлөн зохион байгуулж байгаагаас 100 хувь хэрэгжсэн 4, 70 хувь хэрэгжсэн 3, хугацаа болоогүй 1 арга хэмжээ байна. Төлөвлөгөөний дундаж хэрэгжилт 76.2 хувьтай байна. Аймгийн Засаг даргын 2017 оны А/136 дугаар захирамжаар “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж байна. Хөтөлбөрийн хүрээнд зорилтод бүлгийн 40-65 насны нийт 3906 хүн амыг хепатитийн В, С вирусын халдварын илрүүлэг шинжилгээнд хамруулахаас 2017 оны 06 сарын 30-ны байдлаар 2785 иргэн буюу 71.3 хувийг хамруулаад байна. Дэлхийн банк, Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хэнийг ч орхигдуулахгүй байх нь“ төслийг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээг “Иргэдийн онооны карт”-ын аргачлалаар үнэлэх үнэлгээ хийгдсэн. Мөн Улсын гуравдугаар төв эмнэлэг болон аймгийн Нэгдсэн эмнэлэгт мэс заслын эмч мэргэжилтний багийг сэлгэн ажиллуулж, нийт 6 төрлийн мэс ажилбар орон нутагт хийгдэн ажлын байрны сургалтаар эмч, мэргэжилтнүүдийг чадавхижууллаа. Эрүүл мэндийн байгууллагын ажилтан, албан хаагчдыг чадавхижуулж, ёс зүй, харилцааны сургалтыг 2 удаа зохион байгуулан, 100 гаруй эмч, мэргэжилтнийг хамруулсан. Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн сургах чиглэлээр аймгийн Эрүүл мэндийн газрын даргыг Бүгд найрамдах Сингапур улсад сургалтанд хамруулсан.	
		Хэрэгжилт 70 хувь					

68		190 ортой нэгдсэн эмнэлгийн шинэ барилгын ажлын хөрөнгө, санхүүжилтийг шийдвэрлүүлнэ.	Ажлын явц	Хөрөнгө, санхүүжилтийг шийдвэрлүүлсэн байна.	-	190 ортой аймгийн Нэгдсэн эмнэлгийн шинэ барилгын төсвийг улсын төсөвт тусгуулах, санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр саналаа холбогдох яамдад хүргүүлсэн.	2018 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.
		Үнэлэх боломжгүй.					
69		Сүмбэр, Шивээговь сумдын Эрүүл мэндийн төвийг түргэн тусламжийн автомашинаар хангана.	Түргэн тусламжийн автомашины тоо	2	Сумдын ОНХС 60.0	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Эрүүл мэндийн яамнаас Сүмбэр, Шивээговь сумдын Эрүүл мэндийн төвийг тус тус түргэн тусламжийн автомашинаар хангасан.	
		Хэрэгжилт 100 хувь					
70		Сумдын эрүүл мэндийн төвийг нөхөн үржихүйн тусламж үйлчилгээнд шаардлагатай тоног, төхөөрөмж, багаж хэрэгслээр хангана.	Нялхсын эндэгдлийн түвшин	0.2-оос дээш хувиар буурсан байна.	Сумдын ОНХС 20.0	Сүмбэр сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 10.0 сая төгрөгийн хөрөнгөөр “Энх тус дэм” өрхийн эрүүл мэндийн төвийг эх, хүүхэд, нөхөн үржихүйн тусламж үйлчилгээнд шаардлагатай 18 нэр 42 ш тоног төхөөрөмж, 3 төрлийн 1100 ш оношлуур, цэрний сав-522, зүрхний цахилгаан бичлэгийн 10 боодол цаасаар хангасан Баянтал сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 3.0 сая төгрөгөөр сумын Эрүүл мэндийн төвийг түргэвчилсэн оношлууараар хангахаар Тавин Ус ХХК-тай гэрээ байгуулаад байна. Нялхасын эндэгдлийг бууруулах чиглэлээр шинэ төрсөн эх нярайн гэрийн эргэлтийг тогтмолжуулж, аймгийн төвд 794, хөдөөгийн багт 106 хүүхдэд гэрийн эргэлтээр асаргаа сувилгаа, хөхөөр хооллох зөвлөлгөө өгч байна. Иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгөх сургалт сурталчилгааг “Бага насны хүүхдийн хооллолт”, “Эсэн мэнд амаржихуйн” сэдвийн хүрээнд 8 удаа зохион байгуулж, 100-д иргэнийг хамруулсан. 2017 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар 199 эх төрж, 199 амьд төрөлтөөс нярайн эндэгдэл бүртгэгдээгүй, нялхсын эндэгдэл 1 бүртгэгдсэн байна.	

		Хэрэгжилт 70 хувь					
71		Зонхилон тохиолдох В, С вирус, сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдвар, хорт хавдрыг эрт илрүүлж, өвчлөл, нас баралтыг бууруулахад шаардлагатай оношлуур тоног төхөөрөмжөөр хангаж эхэлнэ.	Эрт илрүүлэх үзлэгт хамрагдалтын хувь	25-аас дээш хувиар нэмэгдсэн байна.	Сумдын ОНХС 15.0	Баянтал сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 3.0 сая төгрөгөөр сумын Эрүүл мэндийн төвийг түргэвчилсэн оношлууараар хангахаар Тавин Ус ХХК-тай гэрээ байгуулаад байна. Зонхилон тохиолдох В, С вирус илрүүлэх шинжилгээнд эхний улирлын байдлаар 566 иргэн хамрагдаж, Аймгийн Засаг даргын 2017 оны А/136 дугаар захирамжаар “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж байна. Хөтөлбөрийн хүрээнд зорилтод бүлгийн 40-65 насны нийт 3906 хүн амыг хепатитийн В, С вирусын халдварын илрүүлэг шинжилгээнд хамруулахаас 2017 оны 06-р сарын 30-ны байдлаар 2785 иргэн буюу 71.3 хувийг хамруулаад байна. Үүнээс В вирус-193, С вирус-272 нийт 465 хүнд В, С вирус илэрсэн байна. Эмчилгээнд В вирус-37, С вирус-53 нийт 90 хүн дараагийн шатны шинжилгээ, эмчилгээнд хамрагдаад байна. Одоогоор 4 иргэн бүрэн эрүүлжээд байна. Умайн хүзүүний хавдрыг эрт илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамрагдвал зохих иргэдийн 32.3 хувь, хөхний үзлэгт 448 иргэн хамрагдаж, эрт илрүүлгийн үзлэгийн хувь өмнөх оноос 5.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс Сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээг 06 дугаар сарын 15-нд Сүмбэр, Шивээговь суманд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангасан боловч хойшлогдоод байна. БЗДХ-аас сэргийлэх сургалтаар 3 байгууллагын 110 иргэн, сүрьеэ өвчнөөс сэргийлэх сургалтанд ерөнхий боловсролын 160 гаруй сурагчийг хамруулсан. Сүрьеэ өвчний тархалтаас урьдчилан	

						сэргийлэх зорилгоор Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, аймгийн ЗДТГ хамтран “Салбар дундын болон төр, хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах” сургалт, уулзалтыг зохион байгууллаа. Даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн хамралтын хувь-39.8% Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн хувь-38.1% Хөхний хорт хавдрын эрт илрүүлгийн хувь-29.3% Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн хувь -79,5% 2017 оны эхний хагас жилийн байдлаар эрт илрүүлэгийн дундаж 46.7, өнгөрсөн оны суурь түвшин / 2016 оны суурь түвшин 23/-тэй харьцуулахад 103 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	
		Хэрэгжилт 40 хувь					
3.2. Боловсрол, соёл урлаг, спортын салбар							
72	Цэцэрлэг, сургуулийн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлж, боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулна.	Боловсролыг дэмжих аймгийн дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	100 хувь	АОНХС 30.0	Дэд хөтөлбөрийн хүрээнд 15 арга хэмжээг төлөвлөн зохион байгуулж байгаагаас 2 арга хэмжээ 70 хувьтай, 4 арга хэмжээ 40 хувьтай, 7 арга хэмжээ хугацаа болоогүй байна. Төлөвлөгөөний дундаж хэрэгжилт 20 хувьтай байна. Боловсролыг дэмжих хөтөлбөрийн төлөвлөгөөний дагуу дараах арга хэмжээг зохион байгуулллаа. Үүнд: Дэлхийн Зөн Бор-Өндөр ОНХХөтөлбөртэй хамтран байгалийн ухаан, бага анги, цэцэрлэгийн багш нар, эрхлэгч, менежерүүд нийт 120 багш, ажилчдыг Улаанбаатар хотын сургууль, цэцэрлэг болон ШУТИСургуулийн лицей сургууль, Дундговь, Өмнөговь аймгийн сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцуулж, туршлага судлуулсан. Дэлхийн Зөн ОНХХөтөлбөр, Багшийн хөгжлийн нийгэмлэгтэй хамтран “Багшийн ёс зүй” сэдэвт сургалт зохион байгуулж, 10-аас	

						доош жил багшилсан 107 багшийг хамруулсан. Улсын сэтгэх чадварын олимпиадад түрүүлсэн 1 сурагчид 200 000 төгрөгийн, Газарзүйн олимпиадад 2 дугаар байр, Карл Попперийн мэтгэлцээний тэмцээнд тэргүүн байранд шалгарсан 2 багшид тус бүр 150 000 төгрөгийн урамшуулал олгов. Хүүхдийн Яргуй наадамын 9 төрөлд зохион байгуулж 250 хүүхэд оролцсон. Дэлхийн зөн байгууллагаас 1,5 сая төгрөг, хөтөлбөрөөс 540 мянган төгрөгийг зарцуулсан. Математикийн хичээлийн төгсөлтийн болон элсэлтийн ерөнхий шалгалтын хувийг ахиулах зорилгоор 5 удаагийн сорилго шалгалтыг зохион байгууллаа. Аймгийн Засаг даргын нэрэмжит математик, англи хэл, монгол бичгийн олимпиад, Баянтал сумын Засаг даргын нэрэмжит математикийн олимпиадыг зохион байгуулж, нийт 1200-аад сурагч оролцсон. Буян цэцэрлэгийн хүүхдүүдийн тайлан тоглолтыг Улаанбаатар хотноо Монголын Хүүхдийн ордонд зохион байгуулж, 50 гаруй хүүхэд оролцлоо. Аймгийн Засаг даргын 2017 оны А/32 дугаар захирамжаар “Боржигин өв соёлыг өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх” ажлыг зохион байгуулах ажлыг эхлүүлж, Боржигин морин хуур, уртын дууны сургалтанд 80 гаруй хүүхдийг хамруулан, Боржигин хошууны /хуучнаар/ зүүн захын 8 суманд биет болон биет бус өвийн судалгааг хийлээ. Математикийн 2 зөвлөх багштай гэрээ байгуулан багш, сурагчдад сургалт зохион байгуулан ажиллаж байна.	
		Хэрэгжилт 40 хувь					
73		Сүмбэр сумын 100 хүүхдийн Канад загварын цэцэрлэгийн барилгыг	Барилгын ажлын гүйцэтгэл	100 хувь	УТХО 280.0	Сүмбэр сумын 100 хүүхдийн Канад загварын цэцэрлэгийн барилгыг үргэлжлүүлэн барих хөрөнгө шийдвэрлэгдээгүй байна.	Төсөв хөрөнгө нь шийдвэрлэгдээ

		ашиглалтанд оруулна.					гүй.
		Үнэлэх боломжгүй.					
74		2-р сургуулийн 640 хүүхдийн шинэ барилгын ажлыг эхлүүлнэ.	Барилгын ажлын гүйцэтгэл	Хөрөнгө, санхүүжилтийг шийдвэрлүүлж, барилгын ажлын гүйцэтгэл 30 хувь байна.	УТХО 5000.0	Барилгын зураг төсөв боловсруулах ажил хийгдэж байгаа бөгөөд сургуулийн барилгын санхүүжилт шийдвэрлэгдээгүй байна.	Төсөв хөрөнгө нь шийдвэрлэгдээ гүй.
		Үнэлэх боломжгүй.					
75		1-р цэцэрлэгийн хуучин барилгын их засварын ажлыг гүйцэтгэнэ.	Барилгын ажлын гүйцэтгэл	100 хувь	УТХО 200.0	Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн хуучин барилгын их засварын ажлын зураг төсвийг АОНХСангийн 3.0 сая төгрөгөөр ЭйЭнИИ ХХК-аар гүйцэтгүүлэн, хүлээн авч, барилгын засварт шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд хүсэлтийг хүргүүлсэн.	
		Хэрэгжилт 0 хувь					
76		2-р цэцэрлэгийн цахилгааны монтажийн их засварыг хийнэ.	Ажлын гүйцэтгэл	100 хувь	УТХО 41.2	Сүмбэр сумын 2 дугаар цэцэрлэгийн цахилгаан, монтажийн засварын ажлыг УТХО-ын 60.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр тендер шалгаруулалтыг зарлан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах шатанд байна.	
		Хэрэгжилт 40 хувь					
77		Цэцэрлэг сургуулийн их засвар, тохижилтын ажлын зураг төсөв боловсруулна.	Зураг төсөв боловсруулах ажлын явц	Зураг төсвийг бүрэн хийлгэж, хүлээн авсан байна.	АОНХС	Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн хуучин барилгын их засварын ажлын зураг төсвийг АОНХСангийн 3.0 сая төгрөгөөр ЭйЭнИИ ХХК-аар гүйцэтгүүлэн, хүлээн авсан бөгөөд Сүмбэр сумын 1-р сургуулийн биеийн тамирын талбайн зураг төсвийг ЭйЭнИИ ХХК-аар гүйцэтгүүлж, экспертизээр батлуулах шатанд байна. Мөн Баянтал сумын 4-р сургуулийн спорт заалны засвар, Сүмбэр сумын 2-р цэцэрлэгийн гадна цахилгаан, дотор	

						монтажны ажлын төсвүүдийг хийж, төсвийн дагуу ажлуудыг гүйцэтгүүлж байна.	
		Хэрэгжилт 70 хувь					
78		Цэцэрлэгүүдийн тоглоом, зөөлөн эдлэлийг сайжруулна.	Тоглоом, зөөлөн эдлэл сайжруулсан цэцэрлэгийн тоо	2	Сумдын ОНХС 10.0	Дэлхийн Зөн Бор-Өндөр ОНХХөтөлбөрийн санхүүжилтээр “Сансар” цэцэрлэг, 1, 2 дугаар цэцэрлэгийн тус бүр 1 бүлэг, 5 дугаар цэцэрлэгийн 2 бүлэг, нийт 5 бүлгийн 140 хүүхдийн хоолны хэрэгслийг шинэчилсэн. Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэгт сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 5.0 сая төгрөгөөр тоглоом худалдан авсан. Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэг эцэг, эхийн тусламжтайгаар 1 дүгээр ээлжийн 250 хүүхдийн зөөлөн эдлэлийг шинэчилсэн. Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг “Нэг хүүхэд-нэг тоглоом” аян зохион байгуулж, тоглоомыг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Шивээ-Овоо ХК-иас 13.5 сая төгрөгөөр 3 дугаар цэцэрлэгийн сургалтын орчинг тохижуулж, тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангасан.	
		Хэрэгжилт 70 хувь					
79		Дотуур байруудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.	Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан дотуур байрны тоо	2	Сумдын ОНХС 40.0	Жайка ОУБ-ын Өвсний үндэс төслийн хүрээнд 5-р сургуулийн дотуур байрны гадна талын засвар, 3 өрөөний тохижилтыг 168.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж, ашиглалтанд хүлээн авсан. Шивээговь сумын дотуур байрыг сумын ОНХСангийн 7.0 сая төгрөгийн хөрөнгөөр 4 нэр төрлийн гал тогооны тоног төхөөрөмжөөр хангасан.	
		Хэрэгжилт 100 хувь					
80		Хувийн хэвшлийн сургууль, цэцэрлэг шинээр байгуулахыг бодлогоор дэмжинэ.	Газрын бодлогоор дэмжсэн хувийн сургууль, цэцэрлэгийн тоо	1-ээс багагүй.	ХХО	Аймгийн Засаг даргын А/151 дүгээр захирамжаар үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгон, Сүмбэр сумын 1 дүгээр багт “Тунгаамал” цэцэрлэгийг шинээр байгууллаа. 2017 оны байдлаар аймгийн хэмжээнд 5 хувийн хэвшлийн цэцэрлэг үйл ажиллагаа	

						явуулж байна.	
		Хэрэгжилт 100 хувь					
81	Соёл, урлагийн байгууллагуудын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.	Соёл, урлагийг хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	100%	АОНХС 10.0	Аймгийн Соёл, урлагийг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн хүрээнд 2017 онд зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Дэд хөтөлбөрийн хүрээнд 7 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байгаагаас 2 арга хэмжээ 100 хувьтай, 2 арга хэмжээ 70 хувьтай, 1 арга хэмжээ 40 хувьтай, 2 арга хэмжээ хугацаа болоогүй, дунджаар 54.3 хувьтай хэрэгжиж байна. Төлөвлөгөөний дагуу Боржигин биет болон биет бус өвийг судлах ажлыг эхлүүлэн, соёл урлагийн ажилтны сургалт, зөвлөгөөнийг зохион байгууллаа. Мөн Боржигин морин хуурын сургалтыг ЕБС-ийн 5 дугаар сургуулийг түшиглэн зохион байгуулж 80 хүүхдийг хамруулж байна. Аймгийн ОНХСангийн 22.0 сая төгрөгөөр 40 ширхэг Боржигин морин хуур, 4 ширхэг шанаган хуур худалдан авах тендерийг зарлаж, гүйцэтгэгчээр “Хан тэнгэр” ХХК шалгаран гэрээ байгуулаад байна.	
		Хэрэгжилт 40 хувь					
82		Дуу бүжгийн Боржигин чуулгын шинэ барилгын ажлын хөрөнгө, санхүүжилтийг шийдвэрлэнэ.	Ажлын гүйцэтгэл	Хөрөнгө, санхүүжилтийг шийдвэрлүүлсэн байна.	-	Дуу бүжгийн Боржигин чуулгын шинэ барилгын хөрөнгийг шийдвэрлүүлэхээр БСШУС-ын яам, Засгийн газрын хэрэгжүүлэх агентлаг Соёл, урлагийн газарт саналаа хүргүүлсэн.	Төсөв хөрөнгө нь шийдвэрлэгдээгүй.
		Үнэлэх боломжгүй.					
83		Аймаг, сумдын номын сангийн номын фондыг нэмэгдүүлнэ.	Нэмэгдүүлсэн номны тоо	350-аас доошгүй	АОНХС 10.0	Аймгийн Засаг даргын 2017 оны А/25 дугаар захирамжаар аймаг, сумдын номын санд ном худалдан авах ажлын хэсгийг томилж, аймгийн ОНХСангийн 10.0 сая төгрөгөөр ном худалдан авахаар бэлтгэл ажлыг хангаж байна.	
		Хэрэгжилт 40 хувь					

84		Боржигин морин хуур, уртын дууны сургалтыг зохион байгуулж, морин хуураар хангана.	Шинээр худалдан авсан морин хуурын тоо	35-аас доошгүй	АОНХС 25.0	Аймгийн ОНХСангийн 22.0 сая төгрөгөөр 40 ширхэг Боржигин морин хуур, 4 ширхэг шанаган хуур худалдан авах тендерийг зарлаж гүйцэтгэгчээр “Хан тэнгэр” ХХК шалгарч, гэрээ байгуулаад байна. Боржигин морин хуурын сургалтыг 3 сумын 5 сургууль дээр зохион байгуулж 80 орчим хүүхэд хамрагдаж байна.	
		Хэрэгжилт 70 хувь					
85	Иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх таатай орчин нөхцлийг бүрдүүлж, материаллаг баазыг нэмэгдүүлнэ.	Биеийн тамир, спортыг хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	100 хувь	УТХО 16.0 АОНХС 15.0	Аймгийн Биеийн тамир, спортыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн хүрээнд 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Дэд хөтөлбөрийн хүрээнд 5 багц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байгаагаас 2 арга хэмжээ 100 хувьтай, 2 арга хэмжээ 70 хувьтай, 1 арга хэмжээ 40 хувьтай, дунджаар 76 хувьтай хэрэгжиж байна. Төлөвлөгөөний дагуу аймгийн аварга шалгаруулах тэмцээнүүд, Чойр хөгжлийн лиг, “Говьсүмбэр мастер кросс-2017” футзалны талын бүсийн аварга шалгаруулах тэмцээн, хөлбөмбөгийн зүүн бүсийн аварга шалгаруулах тэмцээнүүдийг зохион байгуулсан. Хагас жилийн байдлаар бүсийн аварга шалгаруулах тэмцээнээс 3 алт, 3 мөнгөн медаль, улсын аварга шалгаруулах тэмцээнээс 5 алт, 9 мөнгө, 17 хүрэл медаль хүртээд байна. Аймгийн Засаг даргын нэрэмжит “Спортын бага наадам”-ыг спортын 8 төрлөөр зохион байгуулж 20 багийн 1250 /давхардсан тоогоор/ гаруй тамирчин оролцлоо.	
		Хэрэгжилт 70 хувь					
86		Биеийн тамир, спортын цогцолбор байгуулах ажлын зураг, төсвийг боловсруулна.	Зураг төсөв боловсруулах ажлын явц	Зураг төсвийг бүрэн хийлгэж, хүлээн	АОНХС	2016 оны аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 16.8 сая төгрөгөөр Биеийн тамир, спортын цогцолбор байгуулах ажлын зураг, төсвийг Цээнтэй Ателейр ХХК-аар гүйцэтгүүлэн, экспертизээр батлуулан, хүлээн	

				авсан байна.		авсан.	
		Хэрэгжилт 100 хувь					
87		Биеийн тамир, спортын газрын барилгыг засварлана.	Барилгын ажлын гүйцэтгэл	100 хувь	УТХО 40.0	Аймгийн Биеийн тамир, спортын газрын барилгын засварыг улсын төсвийн 75.1 сая төгрөгөөр, Усан спорт, сургалтын төвийн барилгын засварыг улсын төсвийн 128.9 сая төгрөгөөр тус тус гүйцэтгүүлэхээр тендер зарлаад байна.	
		Хэрэгжилт 40 хувь					
3.3. Хүн ам, хөдөлмөр эрхлэлт,нийгмийн хамгааллын салбар							
88	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдлийг бууруулна.	Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүртээмж, үр ашгийг дээшлүүлж, ажилгүйдлийг бууруулна.	Байнгын ажлын байр Түр ажлын байр	300-аас доошгүй 350-аас доошгүй	ХЭДС	Ажил хаагч 136 иргэнийг хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн санд шинээр бүртгэсэн. Нийт ажил идэвхитэй хайгчаар 461 иргэн бүртгэлтэй байна. 115 ААНБ-аас 197 сул ажлын байрны захиалга авч 128 иргэнийг байнгын ажлын байранд зуучилсан. Ажил олоход хүндрэлтэй ажил хаагч 182 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө өгч, суралцах чиглэл ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн сургалтыг 2 байгууллагын 139 иргэнд хийж бүлгийн зохион байгуулалтаар хүнсний ногоо тариалах арга хэмжээнд 16 иргэнийг хамруулсан.	
		Хэрэгжилт 40 хувь					
89		Зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилчдын хөдөлмөрлөх нөхцлийг сайжруулна.	Нийгмийн хариуцлагын гэрээ байгуулсан ажил олгогчдын хувь Ажилчдын нийгмийн даатгалд хамрагдалтын хувь	100 хувь. 100 хувь.	-	Ажил олоход хүндрэлтэй 3 иргэнийг зуучилж ажил олгогчийн урамшуулалд хамруулахаар 2 ажил олгогчтой гэрээ байгуулан, байнгын ажлын байраар хангасан. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч 9 ААН-тэй холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр хамтран ажиллаж байна. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Политехникийн коллеж хамтран Төрийн болон хувийн хэвшлийн 8 байгууллагын ХАБЭА шинэ ажилтнуудад ХАБ-ийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан.	

						Үйлдвэрлэлийн дадлагажуулагч багшийг мэргэшүүлэх сургалтанд 10 ААНБ-ийн 22 ажилтан албан хаагчийг хамруулж, 18 албан хаагчид сургагч багшийн гэрчилгээ олголоо. Мэргэжлийн хяналтын газартай хамтран Зохистой хөдөлмөр эрхлэлтийн сарын аяныг 05 сарын 15-аас эхлэн зохион байгуулсан. Сарын аяны хүрээнд Мэргэжлийн хяналтын газартай хамтран Шивээ Овоо ХК, Илчлэг Шивээ ХХК, Шивээ сервис ХХК зэрэг газруудад Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй цалин хөлс олгож байгаа эсэх талаарх болон Хөдөлмөрийн тухай хуулийн 111-р зүйлийн хэрэгжилтийн талаарх үзлэг шалгалтыг зохион байгууллаа. Үзлэг шалгалтаар Шивээ овоо ХК-д ажиллаж буй Хөгжлийн бэрхшээлтэй 8 иргэний Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрийн хугацаа дууссан байсан тул сунгалт хийлгэсэн. Мөн МХГ-аас Хөгжлийн бэрхшээлтэй иргэний төлбөрийг хугацаанд нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлж байх талаар зөвлөмжийг өгсөн. Мөн МХГ, Эрүүл мэнд нийгмийн даатгалын хэлтэстэй хамтран Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, эрсдлийн үнэлгээ хийх арга сэдэвт сургалтыг Стандарт Спорт ХХК, Эко нуур ХХК, Бүрэн Урлан ХХК, Умард говийн ГХДТСГазрын захиргаа, Хэрлэн Энерго, Эф Би Эл Жи ХХК, Сүмбэр хөгжлийн гүүр ХХК зэрэг аж ахуйн нэгж байгууллагын төлөөллүүдэд зохион байгуулсан.	
		Хэрэгжилт 40 хувь					
90	Зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, нийгмийн халамжийн	Зорилтот бүлэгт чиглэсэн аймгийн дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	100 хувь	АОНХС 30.0	Дэд хөтөлбөрийн хүрээнд 14 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байгаагаас 3 арга хэмжээ 100 хувьтай, 2 арга хэмжээ 70 хувьтай, 2 арга хэмжээ 40 хувьтай, 7 арга хэмжээ хугацаа болоогүй, дунджаар 37.1 хувьтай хэрэгжиж байна. Зорилтот бүлэгт чиглэсэн аймгийн дэд	

	бодлогыг хэрэгжүүлэн, ядуурлыг бууруулна.					хөтөлбөрийн хүрээнд сэтгэл зүйч, доктор Г.Наранбаатарыг урьж “Жендерийн эрх тэгш байдлыг хангахад залуучуудын оролцоо” сэдвээр уулзалт зохион байгуулж, 150 гаруй иргэн оролцсон. Энэхүү үйл ажиллагааны зардалд 635 мянган төгрөг зарцуулсан.. Мөн 80-аас дээш настай 126 ахмадад хүндэтгэл үзүүлж, 3 сая төгрөг зарцуулсан. Ахмад настнуудын дунд соёл, спортын арга хэмжээ, Хүүхдийн эрхийг хамгаалах тэднийг хөгжүүлэхэд чиглэгдсэн соёл урлагийн арга хэмжээнд 2 500.0 мянган төгрөг, Хүүхдийн хүмүүжил гэр бүлээс эхтэй эцэг, эхийн зөвлөгөөнд 500 мянган төгрөг, орон гэргүй иргэдийн өрхийн амьжиргааг дээшлүүлэх ажлын хүрээнд 300 мянган төгрөг тус тус зарцуулсан. Нийт 6,935,000 төгрөг зарцуулаад байна.	
		Хэрэгжилт 40 хувь					
91		Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвтэй болно.	Хөгжлийн төвийн тоо	1	-	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын өмчлөлд байсан ажлын байрны 2 дугаар давхрыг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв болгон ашиглахаар шийдвэрлэсэн. Тус байрны ашиглах журмыг боловсруулж, ахмад настны зөвлөх үйлчилгээ явуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.	
		Хэрэгжилт 40 хувь					
92		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг сайжруулна.	Шинээр хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажлуудад дэд бүтэц төлөвлөлтийн хувь Дэд бүтцийг шийдвэрлэсэн ААНБ-ын хувь	100 хувь 100 хувь	-	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх барилга байгууламж, замын ажлын зураг төсөвт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг тусгаж байна. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын барилга, Сүмбэр сумын өрхийн эрүүл мэндийн төвийн өргөтгөл, Биеийн тамир, спортын цогцолбор, 1-р цэцэрлэгийн, 1-р байрны засвар, гадна тохижилтуудын ажлуудын зураг төсөвт дэд бүтцийг шийдвэрлэхээр тусган, хэрэгжүүлж эхэлсэн.	

		Хэрэгжилт 40 хувь					
93		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн авч ажиллуулсан 25 ба түүнээс дээш ажиллагсадтай ААНБ-ууд	100 хувь	-	Аймгийн хэмжээнд 25-аас дээш ажилтантай 36 ААНБ байгаагаас 12 байгууллага нь 40 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн авч ажиллуулаагүй 6 байгууллага 1.8 сая төгрөгийн төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлээд байна. Төлбөрөө төлөөгүй 18 ААН-д мэдэгдэл хүргүүлсэн.	
		Хэрэгжилт 70 хувь					
94	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжсэн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	“Гэр бүл, хүүхэд, залуучуудад сэтгэл зүйн зөвлөгөө өгөх танхим"-ын үйл ажиллагааг тогтмолжуулна.	Шаардлагатай иргэдэд үйлчилгээ үзүүлсэн хувь	100 хувь	ОУБ 3.6	Гэр бүл, хүүхэд, залуучуудад зөвлөгөө өгөх танхимаар дамжуулан хагас жилийн байдлаар нийт 48 иргэн, 67 хүүхдэд гэр бүлийн харилцаа, өсвөр насны хүүхдийн онцлог, хэрхэн харилцах, "Гэр бүлийн хүчирхийлэлийн хэлбэр", “Өсвөр насны хүүхдийн зан харилцааны онцлог", "Бага насны хүүхдийн сэтгэл зүйн онцлог” сэдвийн хүрээнд сэтгэл зүйн зөвлөгөөг өгч ажилласан. Мөн 3 иргэнд 2-3 удаагийн давтамжтайгаар сэтгэл зүйн зөвлөгөө, ерөнхий боловсролын 3 сургуулийн нийт 750 хүүхдэд "Хүүхэд бидний төлөвшилд нөлөөлж буй хүчин зүйл" сэдэвт сэтгэл зүйн сургалтыг тус тус зохион байгууллаа.	
		Хэрэгжилт 70 хувь					
95		Гэр бүл, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх байрыг шийдвэрлэнэ.	Ашиглалтанд оруулсан байрны тоо	1-ээс багагүй	-	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх, хохирогчийг хамгаалах "Түр хамгаалах байр"-ыг бий болгож ашиглалтанд хүлээн авлаа. Байрны тохижилтонд шаардлагатай 18 төрлийн тавилга эд хогшлыг аймгийн ОНХС-ийн 6.0 сая төгрөгөөр худалдан авах гэрээг “Дэлгэрэх билэг” ХХК-тай байгуулаад байна.	
		Хэрэгжилт 70 хувь					
96		Зорилтот бүлгийн	Хөнгөлөлттэй	100 хувь	ОНТ	Сүмбэр сумын 2, 3 дугаар багт оршин суудаг	

		гишүүдийг хөнгөлөлттэй үнээр тээвэрлэх, нийтийн тээврийн бодлогыг хэрэгжүүлнэ.	үнээр тээвэрлэх нөхцөл бүрдсэн байна.		2.5	хүүхдүүдийг хөнгөлөлтэй үнээр тээвэрлэх ажлын хүрээнд нийт сургуулийн хүүхдийн харьяаллын судалгааг авсан. 2017 оны 09 дүгээр сараас холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	
		Хэрэгжилт 0 хувь					
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО							
4.1. Байгаль, хүний эрүүл мэндэд ээлтэй ногоон хөгжлийн чиглэлээр							
97	Цаг агаарын аюулт үзэгдэл, байгалийн гамшгийн эрсдлээс урьдчилан сэргийлнэ.	Цаг агаарт зориудаар нөлөөлөх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулна.	Арга хэмжээний үр дүнгийн хувь	100 хувь	УТХО 20.0	Цаг агаарт зориудаар нөлөөлөх чиглэлээр 3 ажилтныг сургаж, мэргэжлийн үнэмлэхтэй болгосон. Цаг агаарт нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг 2017 оны 05 дугаар сарын 01-ээс 09 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд зохион байгуулахаар төлөвлөсөн. 26 ширхэг пуужингийн нөөцтэй байгаа бөгөөд 05 дугаар сарын 20-нд үүлэнд зориудаар нөлөөлөх арга хэмжээг зохион байгуулж, 3 пуужин харвасан нь 100 хувь үр дүнтэй болсон. Цаашид цаг агаарын байдал, үүлний хэв шинжээс хамааруулан цаг агаарт нөлөөлөх арга хэмжээг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлнэ.	
		Хэрэгжилт 40 хувь					
98		Цаг агаарын урьдчилсан мэдээ, дулаан хүйтний улирлын төлөв, аюулт үзэгдлийн сэрэмжлүүлэх мэдээг иргэдэд шуурхай хүргэж, мэдээллийг хялбар авах боломжоор хангана.	Мэдээллийг цаг тухай бүрт мэдээллийн хэрэгсэл болон цахимаар хүргэсэн байдал	100 хувь	-	Цаг агаарын нарийвчилсан болон хоногийн тойм мэдээг 9 цаг 30 минутын дотор, 1-5 хоногийн урьдчилсан мэдээг 14 цаг 30 минутын дотор, 7 хоногийн төлөв, 7 хоногийн тойм мэдээг даваа гариг бүр, сарын урьдчилсан мэдээг 25-ны өдрийн дотор, сарын тойм мэдээг 05-ны өдрийн дотор www.govisumber.tsag-agaar.gov.mn цахим хуудсанд байршуулж, аймгийн “Залуус” телевизээр 5 хоногийн цаг агаарын урьдчилсан мэдээг явуулж байна. Аймаг, сумын ИТХ, ЗДТГ, МХГ, ХХААГ, ОБГ, БОАЖГазруудад сарын төлөв мэдээгээр сар бүрийн 27-ны өдрийн дотор хүргүүлж ажилласан.	

						2017 онд цаг агаар тодорхойлолт лавлагааг 3 иргэн, ААНБайгууллагад олгоод байна.	
		Хэрэгжилт 70 хувь					
99	Ногоон бүс, ойн зурвас байгуулах, газрын хөрсийг нөхөн сэргээх замаар байгаль орчны доройтлыг сааруулна.	Аймаг, сумдын төвд ногоон байгууламжийн бичил цэцэрлэг байгуулна.	Шинээр байгуулсан ногоон байгууламжийн бичил цэцэрлэгийн хэмжээ Модны тоо	Сүмбэр – 2 га Шивээговь – 1 га Баянтал – 1 га 2000-аас доошгүй	Сумдын ОНХС 35.0	МУ-ын Ерөнхийлөгчийн 2010 оны 63-р зарлигийн дагуу “Бүх нийтээр мод тарих” өдрийг АЗД-ын 2017 оны А/105 дугаар захирамжаар зохион байгууллаа. Тус ажлын хүрээнд аймгийн хэмжээнд 5710 мод бут шинээр тарьсан. 5 га талбайд 3100 мод бут, ААНБайгууллага-1047 мод бут, Сүмбэр сумын 5 дугаар сургуулийн дотуур байрны гадна 1 га талбайд бичил цэцэрлэг байгуулан 760 мод бут, Шивээговь сум хуучин бичил цэцэрлэгийн 0.5 га талбайд 65 мод бут, Баянтал сум хуучин бичил цэцэрлэгийн 0.5 га талбайд 738 мод бут тарьсан байна.	
		Хэрэгжилт 100 хувь					
100		Ойн ангийн үйл ажиллагааг дэмжин, мод үржүүлгийн газрыг өргөтгөж, ойн зурвасыг хамгаална.	Мод, бутны амьдралт, ургалтын хувь	70 хувь	БХНСАХЗ 15.0	Ойн ангийн үйл ажиллагааг дэмжин, БХНСАХЗардлын 15.0 сая төгрөгөөр ногоон байгууламжийн арчилгаа, усалгаа, агротехникийн арга хэмжээ, 2017 онд УТХО-ын 10.0 сая төгрөгөөр 5 га талбайд ойн зурвас байгуулж, 3100 мод, бут тарьж, БХНСАХЗ-ын 8.0 сая төгрөгөөр хамгаалалтын хашаа барих ажлыг гүйцэтгээд байна. Сум дундын ойн анги нь одоогийн байдлаар төвийн ногоон байгууламжийн 35 га талбайн 50000 гаруй мянган мод бутны арчилгаа усалгааг хийж байна. Япон улсын Каназавагийн технологийн их сургуулийн Экологийн боловсролын төв ТББ, Бөөрөг дэлийн элс ХХК-ийн хөрөнгө оруулалтаар Соёл, спорт, амралтын хүрээлэнд худаг шинээр гаргаж, БХНСАХЗ-аар 2 худаг засварлаж, ашиглалтанд хүлээлгэн өгсөн. Мод үржүүлгийн газарт намираа услалтын системийг ашиглалтад оруулаа. Мод үржүүлгийн газарт хагас жилийн байдлаар улиасны мөчир 650 ширхэг,	

						улиасны 1-2 настай тарьц 1400 ширхэг, хайлаасны 1 настай тарьц 10200 ширхэг, шар хуайсны 2 настай 300 ширхэг, бүйлс 300 ширхэг, далан хальс 1 настай 3000 ширхгийг бойжуулгын талбайд шилжүүлэн суулгаад байна. 120 м^2 хэмжээтэй 2 хүлэмжинд Бургасны мөчир 380 ширхэг, Сухайн мөчир 480 ширхгийг суулган, бүйлс, шар хуайс, далан хальс, хайлаасыг үрээр үржүүлж байна. Модны ургалт, амьдралт 80-85 хувьтай байна.	
		Хэрэгжилт 70 хувь					
101		Ойн зурваст усалгааны систем суурилуулна.	Суурилуулсан усалгааны системийн урт	10000 м	БХНСАХЗ 30.0	БХНСАХЗ-ын 20.3 сая төрөгөөр Соёл, спорт амралтын хүрээлэн, авто замын дагуух ойн зурваст услалтын систем суурилуулах ажлын гүйцэтгэгчээр Гидротехинженеринг ХХК-тай гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн.	
		Хэрэгжилт 70 хувь					
102		Хуримтлагдсан хур хог хаягдал, туурь балгасыг цэвэрлэж нөхөн сэргээнэ.	Цэвэрлэх талбайн хэмжээ	5 га	-	Хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд 18 удаа нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулж, 114 тн хог хаягдлыг цэвэрлэж, хогийн цэгт төвлөрүүлсэн. Аймгийн Засаг даргын 2017 оны А/179 дүгээр захирамжаар 2017 оны 06 дугаар сарын 01-ээс 07 дугаар сарын 01-ний өдрүүдэд “Цэвэр сайхан орчин” аян зарлаж 1 га талбайн 374 м^3 хур хог хаягдал, туурь балгасыг цэвэрлээд байна.	
		Хэрэгжилт 40 хувь					
4.2. Экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, байгаль хамгаалах ажилд бүх нийтийн оролцоог хангах чиглэлээр							
103	Усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалж, зохистой ашиглана.	Булаг, шанд, рашааны эхийг хамгаална.	Шинээр хамгаалсан булаг, шандны тоо	2	БХНСАХЗ 7.0	БХНСАХЗ-аас 7.0 сая төгрөгөөр Шивээговь суманд Бэхтийн булаг, Сүмбэр суманд Өгөөмөрийн голыг хашиж хамгаалах ажлыг Өөдлөх Өгөөмөр иргэдийн бүлгээр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан, ажлыг эхлүүлсэн.	
		Хэрэгжилт 70 хувь					
104		Шивээговь сумын ундны усны эх үүсвэрийг орон	Ажлын гүйцэтгэл	100 хувь	-	Талын Илч ОНӨҮГ, Илчлэг Шивээ ОНӨҮГ-уудын 2017 оны Байгаль орчны	

		нутгийн тусгай хамгаалалтанд авч, хамгаалалтын горимыг мөрдүүлнө.				менежментийн төлөвлөгөө, ус ашиглах гэрээнд ус хангамжийн эх үүсвэрийг орон нутгийн тусгай хамгаалалтад авч тэмдэгжүүлэх ажлыг тусган баталсан.	
		Хэрэгжилт 0 хувь					
105	Байгаль орчныг хамгаалж, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглан, ашиглалтыг сайжруулахад олон нийтийн оролцоог хангана.	Иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Тогтвортой хөгжлийн боловсролыг дэмжих дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	100 хувь	БХНСАХЗ 3.0	Иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх дэд хөтөлбөрийг Тогтвортой хөгжлийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр болгон шинэчлэн боловсруулахаар ажлын хэсэг байгуулагдаад байна. Уг хөтөлбөрийн хүрээнд Дэлхийн Ус ба Ойн өдрийг тохиолдуулан 03 сарын 21, 22-ны өдрүүдэд өдөрлөг зохион байгуулж Усны нөөц ашиглалт, зүй зохистой хэрэглээ, мод бут тарих, хөрс бэлтгэх талаар үзүүлэлт сургалтыг хийн, 20 гаруй иргэн, аж ахуйн нэгжийн төлөөллийг хамруулсан. Бүх нийтээр мод тарих үндэсний өдрийн хүрээнд ажлын төлөвлөгөө гарган тарьц суулгацын үзэсгэлэн, бүх нийтээр мод тарих өдрүүд болон ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг сурталчлан орон нутгийн телевиз, радиогоор 18 мэдээллийг 4 удаагийн давтамжтайгаар нэвтрүүлж, 180 гаруй сурталчилгааны материал тараасан. Мөн БОАЖЯамнаас жил бүр зохион байгуулдаг “International Travel Mart-2017” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцож, аймаг орон нутгийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл бүхий гарын авлагыг тарааж, сурталчлан танилцууллаа.	
		Хэрэгжилт 40 хувь					
106		Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлж, аргаль хонь, тарвага болон бусад амьтдыг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Нэмэгдүүлсэн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ	120 га	БХНСАХЗ 7.0	АИТХ-ын 2017 оны 05 дугаар тогтоолоор 2 газрын 17292.87 га талбайг орон нутгийн тусгай хамгаалалтанд шинээр авснаар аймгийн хэмжээнд 9 газрын 82724.26 га газар тусгай хамгаалалтанд орж, тусгай хамгаалалттай газрын хэмжээ 20.9 хувиар нэмэгдсэн. Тусгай хамгаалалттай газар нутгийн	

						менежментийг сайжруулах ажлын хүрээнд аргаль хонийг хамгаалан биотехникийн арга хэмжээг 2 удаа зохион байгуулан, 40 боодол өвс, 1 тн хужир тавьж өгсөн. Тус ажилд БХНСАХЗ-аас 2.08 сая төгрөгийг зарцууллаа. Мөн байгаль хамгаалагчийн хяналтын пост, мэдээллийн төвийг байгуулж 3*5 харьцаатай байгаль хамгаалагчийн байр барьж, тохижуулсан. Эргүүл шалгалтын ажлыг 14 хоног тутамд зохион байгуулж ажилласны үр дүнд зөрчил гараагүй байна.	
		Хэрэгжилт 70 хувь					
107		Байгаль хамгаалагчдыг шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангасан байна.	Шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангасан байгаль хамгаалагчийн тоо	4-өөс доошгүй	БХНСАХЗ 10.0	БХНСАХЗ-ын 4.13 сая төгрөгөөр Туна электроникс ХХК-тай гэрээ байгуулан, дижитал зургийн аппарат, зургийн аппаратны дуран, сонирхогчийн аппарат, нэмэлт төхөөрөмжүүд худалдан авч, 3 байгаль хамгаалагчийг тоног төхөөрөмжөөр хангаад байна.	
		Хэрэгжилт 70 хувь					
108		Мод, бут тарьсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудыг урамшуулж, ногоон байгууламж бий болгоход олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.	Таригдсан модны тоо Иргэдийн оролцооны хувь хэмжээ	2000-аас доошгүй 1.2 дахин нэмэгдэнэ.	БХНСАХЗ 6.8	Хаврын бүх нийтээр мод тарих ажилд нийт 2639 мод таригдсанаас 25 байгууллага 2136 ширхэг мод сөөг, мөн Япон улсын иргэн Нишида 200 мод, Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийг 1996 онд төгсөгчид 243 мод сөөг, Говьсүмбэр аймгийн Бэх хоршоо 60 мод сөөгийг тарьж, 8.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. 2017 оны модны урамшууллыг 10 сард олгохоор мод, бутыг бүртгэлжүүлэх ажлыг эхлүүлсэн.	
		Хэрэгжилт 70 хувь					
109		Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн, ТББ, идэвхитэн байгаль хамгаалагчидтай хамтран ажиллана.	Нэмэгдсэн нөхөрлөлийн тоо Нэмэгдсэн идэвхитэн байгаль хамгаалагчдын тоо	1 5	БХНСАХЗ 6.0	Хууль бус ан агнуур, хээрийн түймрээс хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2017 оны А/96 дугаар захирамжаар эргүүл шалгалтын хуваарь, төсвийг батлуулан, 7 удаа эргүүл шалгалтын ажлыг зохион байгуулаад байна.	

						Байгаль хамгаалах нөхөрлөлийн чуулга уулзалтанд Хээнцийн уул, Уулзварын гол нөхөрлөл, Монголын Байгаль орчны иргэний зөвлөлийн Говьсүмбэр аймаг дахь салбарын төлөөлүүдийг оролцууллаа. Хээнцийн уул нөхөрлөлтэй хамтран аргаль хонийг хамгаалах зорилгоор 2 удаагийн биотехникийн арга хэмжээ зохион байгуулсан. Идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаа 2 нөхөрлөл, 2 иргэдийн бүлэг, 33 идэвхитэн байгаль хамгаалагчийн үйл ажиллагааг дэмжин, хамтран ажиллаж байна.	
		Хэрэгжилт 70 хувь					
110		Аймгийн биологийн төрөл зүйлийн судалгаа хийлгэнэ. /амьтан, ургамал/	Судалгааны ажлын явц	Судалгааны ажил бүрэн дуусаж, хүлээн авсан байна.	БХНСАХЗ 10.0	Аймгийн биологийн төрөл зүйлийн судалгааг БХНСАХЗ-ын 10.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр зөвлөх үйлчилгээний тендер зарлаад байна.	
		Хэрэгжилт 40 хувь					
4.3. Аялал жуулчлалын салбар							
111	Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлж, менежментийг боловсронгуй болгож, материаллаг баазыг бэхжүүлнэ.	Аялал жуулчлалыг хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт Нэмэгдсэн жуулчдын тоо	100 хувь Өмнөх жилээс 10-аас доошгүй хувиар	АОНХС 10.0	Аймгийн Засаг даргын 2017 оны А/74 дугаар захирамжаар 2017 онд хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан, 27 арга хэмжээг төлөвлөснөөс 2 арга хэмжээг 100 хувь, 8 арга хэмжээг 70 хувь, 8 арга хэмжээг 40 хувьтай хэрэгжүүлэн, 9 арга хэмжээг зохион байгуулах шатанд байна. Хагас жилийн байдлаар төлөвлөгөөний дундаж хэрэгжилт 47.2 хувьтай байна. Хэрэгжүүлсэн арга хэмжээнээс дурьдвал: БОАЖЯамнаас жил бүр зохион байгуулдаг “International Travel Mart-2017” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцож, аймаг орон нутгийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл бүхий гарын авлагыг иргэд олон нийтэд тараан, сурталчлан танилцууллаа.	

						Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулж буй Байгалийн нөөцийн хамтын менежментийн "Байгаль хамгаалах нөхөрлөлүүдийн үндэсний 2 дугаар чуулган"-нд аймгаас БОАЖГ, Сүмбэр сумын Засаг дарга, МБОИЗ-ийн Говьсүмбэр аймаг дахь салбарын тэргүүн, Уулзварын гол нөхөрлөл, Хээнций уул нөхөрлөлийн ахлагч нар оролцож, Сүмбэр сумын Засаг дарга Байгаль орчинд ээлтэй нөхөрлөлүүдийг дэмждэг Засаг дарга өргөмжлөл хүртсэн байна. Аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах аймгийн танилцуулга гарын авлага, боршурын эх хувийг бэлтгэх судалгааны ажил хийгдэж байна. Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн, Аялал жуулчлалын холбоо ТББ-ын ажилчдад “Хөдөөгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх” сэдэвт сургалтыг 1 удаа зохион байгуулсан.	
		Хэрэгжилт 40 хувь					
112		Аяллын тогтсон маршрутын дагуу түүх, соёлын өвийг сэргээж, хамгаалан, тохижуулах ажлын зураг, төсвийг боловсруулна.	Зураг төсөв боловсруулах ажлын явц	Зураг төсвийг бүрэн хийлгэж, хүлээн авсан байна.	АОНХС 10.0	ЭйЭнИИ ХХК-тай гэрээ байгуулан Зүүн Чойрын хийдийн орчмын тохижилтын ажлын зураг төсвийг боловсруулах ажил хийгдэж байна.	
		Хэрэгжилт 40 хувь					
113		Аяллын маршрутын дагуу түр буудаллах цэгүүдийг байгуулна.	Байгуулсан түр буудаллах цэгийн тоо	1	АОНХС 10.0	Аймгийн үдэлт, угталтын хаалгыг шинээр байгуулах зураг төсвийг ЭйЭнИИ ХХК-тай гэрээ байгуулан хийлгэж байна. Үдэлт, угталтын хаалгыг түшиглэн түр буудаллах цэг байгуулахаар төлөвлөсөн.	Хөрөнгө шийдвэрлэгдээгүй
		Хэрэгжилт 40 хувь					
114		Аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдийг зохион байгуулж, улсын болон олон улсын үзэсгэлэнд оролцоход дэмжлэг	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2-оос доошгүй	Хөтөлбөрөөс	БОАЖЯамнаас жил бүр зохион байгуулдаг “International Travel Mart-2017” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцож, аймаг орон нутгийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл бүхий гарын авлагыг иргэд олон	

		үзүүлнэ.				нийтэд тараан, сурталчлан танилцууллаа.	
		Хэрэгжилт 40 хувь					
115		Жуулчны бааз, отог байгуулахыг бодлогоор дэмжиж, гадаад, дотоодын аялагчдыг хүлээн авна.	Байгуулагдсан бааз, отгийн тоо Хүлээн авсан жуулчдын тоо	1 100-аас доошгүй	ХХО	Сүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар 2 га газрыг аялал жуулчлалын зориулалтаар олгохоор шийдвэрлэсэн. Сонгон шалгаруулалт явуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.	
		Хэрэгжилт 40 хувь					
116		Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж, тохирлын гэрчилгээтэй болгоно.	Тохирлын гэрчилгээтэй болсон зочид буудал, зоогийн газрын тоо	3-аас доошгүй	ХХО	2017 оны хагас жилийн байдлаар харьяаллын дагуу Дорноговь аймгийн стандартчилал хэмжил зүйн төвөөс манай аймгийн 1 зочид буудал, 14 зоогийн газарт тохирлын гэрчилгээ олгосон.	
		Хэрэгжилт 40 хувь					
ТАВ.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО							
5.1. Тогтвортой, хариуцлагатай эрх зүйт төрийг төлөвшүүлэх чиглэлээр							
117	Төрийн албан хаагчийн харилцаа, хандлага, ёс зүйг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлнэ.	Төрийн албан хаагчдын харилцаа, хандлага, ёс зүыг сайжруулахад чиглэсэн аймгийн дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Хөтөлбөрийн тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	100 хувь	АОНХС 15.0	Аймгийн Засаг даргын 2017 оны А/32 дугаар захирамжаар хөтөлбөрийн төлөвлөгөө болон, төсвийн зардлыг батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд 2017 оны 02 дугаар сард “Сум, багийн Засаг дарга, ЗДТГ-ын албан хаагчдад зориулсан сургалт”, 2017 оны 03 дугаар сард Төрийн албаны зөвлөлтэй хамтран аймгийн хэмжээний удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөл, Ёс зүйн хорооны гишүүдийг хамруулсан “Говьсүмбэр аймгийн төрийн албан хаагчдын нэгдсэн сургалт”-ыг тус тус зохион байгууллаа. Аймгийн ЗДТГазрын дэргэдэх ёс зүйн хороог шинэчлэн байгуулж, ёс зүйн чиглэлээр 5 удаагийн сургалтыг зохион байгуулж, нийт 490 гаруй албан хаагчийг хамруулав. Мөн аймгийн ЗДТГ-ын бодлогын хэлтэс, агентлагуудаас салбарын үйл ажиллагаатай холбоотой 30 гаруй сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 950 аруй албан хаагч хамрагдсан байна.	

						Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд аймгийн ОНХСангаас 5.0 сая төгрөгийг зарцуулаад байна.	
		Хэрэгжилт 70 хувь					
118		Төрийн албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх нөхцөл, мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх сургалтанд хамруулна.	Зохион байгуулсан сургалтын тоо Мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх сургалтанд хамруулсан албан хаагчдын тоо	3-аас доошгүй 300-аас доошгүй	хөтөлбөр	2017 онд аймгийн хэмжээнд нийт 71 албан хаагчийн хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хянан баталгаажуулж Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 26 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянууллаа. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг сурталчлан таниулах зорилгоор 7 удаагийн сургалтыг зохион байгуулж, 210 албан хаагчийг хамруулллаа.	
		Хэрэгжилт 100 хувь					
119	Төрийн үйлчилгээний ил тод байдлыг ханган, төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй, чанартай хүргэнэ.	Төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг иргэдэд тайлагнах, иргэдээс санал авч үр дүнг үнэлэх ажлыг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулж, өргөдөл гомдлыг шийдвэрлэх хугацааг 2 дахин багасгана.	Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь Санал асуулгад оролцсон өрхийн эзлэх хувь Зохион байгуулсан уулзалт	100 хувь 10 хувь 1-ээс багагүй.	-	Аймгийн хэмжээнд 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар 2960 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирснээс 2923 нь бичгээр, утсаар 31, Засгийн газрын 11-11 төвөөр 6 өргөдөл гомдол, санал хүсэлт ирсэн байна. Үүнээс 2913 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж, 2 өргөдлийг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэж, 45 өргөдлийг шийдвэрлэх шатанд байна. Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлт 99.6 хувьтай байна. Аймгийн Засаг даргаас иргэдтэй хийх уулзалтаас гарсан саналын дагуу шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэн, хариуг хүргүүлэн ажиллаж байна. 2016 оны 12 сарын уулзалтаар санал гаргасан 9 иргэнд хариуг хүргүүлсэн. “Иргэдтэй ажиллах-Нээлттэй өдөрлөг”-ийг аймгийн ЗДТГ-ын НБХ, СТСХэлтэс харъяа агентлагуудтайгаа хамтран тус бүр 1 удаа зохион байгуулллаа. Өдөрлөгийн арга	

						хэмжээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх үүднээс Баянтал, Шивээговь сумдад мөн зохион байгуулж, төрийн үйлчилгээг иргэдэд нэг дор төвлөрүүлэн, нийт давхардсан тоогоор 2508 иргэнд үйлчилгээ үзүүлж, 3500 гаруй гарын авлага, танилцуулах материал тараан, 1464 санал, асуулгыг авч, 1883 иргэнийг соёл, урлаг, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээнд хамруулж, 4391 иргэнд мэдээ, мэдээллийг хүргэж ажилласан. 8-11 дүгээр сард ХОХБТХ, ХЭЗХ, ТЗУХ-үүд тус өдөрлөгийг зохион байгуулахаар төлөвлөж байна. Мэдээллийн ил тод байдлыг хангах арга хэмжээнд аймгийн ОНХСанд 10.0 сая төгрөгийг тусган батлуулж, Үндэсний өдөр тутмын Монголын мэдээ сонинтой 1 жилийн гэрээг 8 900 000 төгрөгөөр байгуулж 14 хоног тутам орон нутгийн мэдээллийг сонин болон www.mminfo.mn сайтаар хүргэж байна. 2017 оны хагас жилийн байдлаар 21 нүүр мэдээлэл хэвлэгдсэнээс гадна өдөр тутам орон нутагт болж буй үйл явдал, мэдээ мэдээллийг тухай бүрт нь сонинд нийтэлж 5000 ширхэгийг иргэдэд үнэ төлбөргүй тараасан. Улс, орон нутгийн www.govisumber.gov.mn, www.mminfo.mn, www.montsame.mn, www.ekhoron21.mn, www.mnb.mn, www.zasag.mn албан ёсны цахим хуудсууд, аймгийн ЗДТГ-ын facebook хуудсаар мэдээллийг хүргэж байна. Орон нутгийн Залуус телевизтэй хамтран ажиллаж, Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааг сурталчлан 3 удаагийн нэвтрүүлгийг иргэдэд хүргэсэн.	
		Хэрэгжилт 40 хувь					
120		Хөдөөгийн багийн төвүүдийг тохижуулна.	Тохижуулсан хөдөөгийн багийн төвийн	3	Сумын ОНХС 41.2	Сүмбэр сумын 2016 оны ОНХСангийн хөрөнгөөр хөдөөгийн багийг тохижуулах ажлын хүрээнд баг тус бүрт 10,0 сая	

			тоо			төгрөгийг зарцуулж, 4-р багийн төвийн цахилгааны асуудлыг бүрэн шийдвэрлэж, чанга яригч, багийн Засаг даргын ширээ, сагс, гар бөмбөгийн тоглоомын талбай хийгдэж байна. 5-р багийн төвийн засварын ажлыг гүйцэтгэж улсын комисс хүлээн авахад бэлэн болсон. 6-р багт иргэдэд үйлчлэх төвийг засварлаж, эд хогшлыг шинэчилсэн.	
		Хэрэгжилт 70 хувь					
121		Аймгийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивыг цахимжуулж, нэгдсэн системд холбох ажлыг эхлүүлнэ.	Ажлын явц	Шаардлагатай тооцоо судалгаа хийж дуусган, ажлыг эхлүүлсэн байна.	УТХО 2.0	Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэргийг цахимжуулах бэлтгэл ажлыг 2014 онд эхлүүлсэн бөгөөд уг ажлын хүрээнд Улсын бүртгэлийн хэлтсийн 7100 ширхэг хувийн хэргийг ангилан ялгаж, цахимжуулахад бэлэн болгосон. Улсын хэмжээнд нэгдсэн журмаар цахимжуулалтын ажлыг зохион байгуулах тул уг ажил хүлээгдэж байна.	
		Хэрэгжилт 40 хувь					
122		Төрийн архивын хадгалалт, хамгаалалтын нөхцлийг сайжруулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.	Цахимжуулах ажлын гүйцэтгэл	40 хувь	-	Архивын Ерөнхий газраас архивын баримт хадгалах зориулалтын 40 ширхэг нягтруулсан шүүгээг хүлээж авсан. Архивын баримт бичгийн цахимжуулалтын 90 хувийг хийж гүйцэтгэсэн.	
		Хэрэгжилт 100 хувь					
123		Төрийн худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулна.	Цахимаар зохион байгуулсан худалдан авалт	100 хувь	-	Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны явцын мэдээллийг тухай бүр www.govisumber.gov.mn болон www.haaa.gov.mn цахим хуудас, Монголын мэдээ, Үнэн сонинд байршуулж байна. Аймгийн Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд 2017 онд 34 худалдан авалт зохион байгуулахаар төлөвлөснөөс 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 31 тендер шалгаруулалтыг зарлаж, үүнээс 10 буюу 32.3 хувийг цахимаар зарлаж, 22 ажлын гэрээ байгуулагдсан.	
		Хэрэгжилт 40 хувь					
5.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах чиглэлээр							

124	Иргэдийн амгалан тайван, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.	Хууль зүйн байгууллагуудын үйлчилгээний чанарыг сайжруулж, иргэдэд эрх зүйн мэдлэг олгох дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	100 хувь	АОНХС 10.0	Аймгийн Засаг даргын 2017 оны А/33 дугаар захирамжаар “Хуулийн байгууллагуудын үйлчилгээний чанарыг сайжруулах, иргэдэд эрх зүйн мэдлэг олгох дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн зардлыг баталж, төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Үүнд: Цагдаагийн хэлтэс болон Шүүхийн Тамгын газартай хамтран Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Эрүүгийн хууль, Прокурорын байгууллагын тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудаар 21 удаагийн сургалт зохион байгуулж, 1820 иргэнийг хамруулан, 3600 ширхэг танилцуулга, гарын авлага тараасан. Аймгийн “Залуус” телевизтэй жилийн хугацаанд 1 сая төгрөгийн гэрээ байгуулж, иргэдэд хууль, эрх зүйн мэдлэг олгох мэдээллийг хүргэж байна. “Иргэдээ сонсъё” аяныг 2017 оны 04 дүгээр сарын 05,06-ны өдрүүдэд зохион байгуулж, Хууль, эрх зүйн хүрээний албан байгууллагын 45 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй баг Шивээговь, Баянтал сумдад ажиллаж, нийт 300 иргэнд үйлчилгээ үзүүлж, 200 иргэнд хууль, эрх зүйн зөвлөгөө өгч, 25 өргөдөл, гомдол хүлээж авч шийдвэрлэн, 450 ширхэг танилцуулга, гарын авлага тараасан. Хуулийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах ажлын хүрээнд хуулийн байгууллагуудын дунд Спортын бага наадмыг 2017 оны 04 дүгээр сарын 28-29-ний өдрүүдэд зохион байгуулаа.	

		Хэрэгжилт 70 хувь					
125		Аймгийн төвийн гудамж, талбайг теле хяналтын камерын системд холбоно.	Камерийн тоо	50	АОНХС 250.0	Аймгийн төвийн гудамж, талбайг теле хяналтын камерын системд холбох ажлыг АОНХСангийн 217.3 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр БИ-СИ-ТИ ХХК-тай гэрээ байгуулан ажлыг эхлүүлээд байна.	
		Хэрэгжилт 70 хувь					
126		Гамшгийн эрсдлээс урьдчилан сэргийлэх олон нийтийг хамарсан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2-оос доошгүй	-	Гамшгийн эрсдлээс урьдчилан сэргийлэх олон нийтийг хамарсан дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүнд: Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн 253 томилгоот бүрэлдэхүүнд 4 удаагийн сургалт зохион байгуулсан. Баянтал суманд гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулж, Баянтал сумын онцгой комисс, орон тооны бус штаб, гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн 42 томилгоот бүрэлдэхүүнийг хамруулав. Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг 8 удаа зохион байгуулан 7911 иргэнд гамшгаас хамгаалах тухай болон Галын аюулгүй байдлын тухай хуулиар яриа таниулга хийсэн. Удирдах бүрэлдэхүүний сургалтыг 2 удаа зохион байгуулж, 53 удирдах албан тушаалтныг, аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд 51 удаагийн сургалт зохион байгуулж, 2863 иргэнийг, Политехникийн коллеж, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад 11 удаагийн сургалт зохион байгуулж, 910 оюутан, сурагчийг тус тус хамруулсан.	
		Хэрэгжилт 70 хувь					
127		Улсын болон цэргийн дайчилгааны даалгаврын хэрэгжилтийг сайжруулна.	Батлан хамгаалахын дайчилгаанд хамрагдалтын хувь	100 хувь	-	Цэргийн тоо бүртгэлийг 2017 оны 01 дүгээр сард зохион байгууллаа. Аймгийн хэмжээнд цэргийн шинэчилсэн тоо бүртгэл 90%-тай, үүнээс Баянтал сум 81%, Сүмбэр сум 94%, Шивээговь 76%-тай хэрэгжсэн. Хугацаат цэргийн албаны 2017 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлага, халалтын ажлыг	

						Зэвсэгт хүчний жанжин штабын даргын тушаал, аймгийн Засаг даргын 2017 оны А/114 дүгээр захирамжийн дагуу зохион байгуулан, хяналтын тоог 100 хувь биелүүллээ. 2017 онд аймгийн хэмжээнд цэргийн дүйцүүлэх албанд 5 иргэнийг элсүүлж авахаар иргэдээс өргөдөл, хүсэлтийг хүлээн авч байна. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн хэлбэрээр орлуулан хаах болзлыг хангасан 77 иргэн 24.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн. “Оюутан цэрэг” хөтөлбөрийн хүрээнд 2017 онд Политехник коллежоос 22 оюутан элсүүлэн цэргийн анхан шатны бэлтгэл сургалтыг 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2 сарын хугацаанд зохион байгуулсан. Сургалтын хөтөлбөрийг бүрэн хангасан, цэрэг татлагын эмчийн үзлэгээр орж тэнцсэн 12 оюутан цэргийг Дорнод аймаг дахь Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн сургалтын төвд шилжүүллээ. Монгол Улсад орчин цагийн зэвсэгт хүчин үүсч хөгжсөний 96 жилийн ой, Монгол хүн сансарт ниссэний 36 жилийн ойг тохиолдуулан аймгийн Цэргийн штаб, хөнгөн атлетикийн холбоотой хамтран Кросс гүйлтийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 4 насны ангиллаар, аймгийн удирдах албан тушаалтнуудын дунд “Спортын 4 төрөлт тэмцээн”, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Цагдаагийн хэлтэс, Төмөр замын Чойр дахь хамгаалалтын анги, Онцгой байдлын газрын албан хаагчдын дунд “Явган марш”-ийг тус тус зохион байгууллаа.	
		Хэрэгжилт 70 хувь					
5.3. Гадаад харилцааны салбар							
128	Аймгийн гадаад харилцааг өргөжүүлэн,	Аймгийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг салбараар хөгжүүлэх дэд	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	100 хувь	АОНХС 10.0	Тус хөтөлбөрийн хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүнд: Зүүн хойд Азийн нутгийн захиргаадын	

	хөгжүүлнэ.	хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.				холбооноос БНСУ-ын Жэжү мужид зохион байгуулсан “Гадаад харилцааны мэргэжилтнүүдийн хурал”-д Сүмбэр сумын ИТХ-ын дарга Т.Түмэнбаяр, Эрүүл мэндийн яамны шугамаар Сингапур улсад “Нийгмийн эрүүл мэндийн удирдлага”-ын чиглэлээр, ЗГХЭГазраас санаачлан Шри-Ланк улсын “Нээлттэй засгийн түншлэл, төрийн нээлттэй өгөгдлийн хөтөлбөрийн хүрээнд туршлага судлах, бодлогын баримт бичиг, эрх зүйн орчин, хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлын талаар санал солилцох, орон нутгийн удирдлагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх” сэдэвт сургалтанд аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ж.Оюунбилэг хамрагдсан. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр аймгийн Эрүүл мэндийн газрын дарга Ц.Мөнх-Одыг Бүгд найрамдах Сингапур улсад сургалтанд хамруулж, Тайвань улсад зохион байгуулагдсан Эрүүл мэндийн салбарын Олон улсын бага хуралд Нэгдсэн эмнэлгийн дарга С.Ариунгэрэлийг оролцууллаа. Мөн БОАЖЯамнаас жил бүр зохион байгуулдаг “International Travel Mart-2017” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцож, аймаг орон нутгаа сурталчлан ажилласан.	
		Хэрэгжилт 40 хувь					
129		Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийг дэмжин, хамтран ажиллана.	Идэвхтэй оролцсон уулзалт, үзэсгэлэнгийн тоо	5-аас багагүй	-	Дэлхийн Зөн ОУБ, ЖАЙКА ОУБ, Улаан Загалмайн нийгэмлэг, Тогтвортой амьжиргаа төслүүдтэй хамтран ажиллаж байна. Япон улсын Засгийн газрын “Өвсний үндэс – Хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламжийн хөтөлбөр”-ийн 184.0 сая төгрөгийн санхүүжилтээр Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн дотуур байрны дотор, гадна засал фасад, цахилгаан, дулааны шугамын ажлуудыг хийж, ашиглалтанд хүлээн авсан.	

						Гэр оронгүй болсон нэг өрхөд Улаан Загалмайн хороотой хамтарч гэр, зөөлөн эдлэл олгосон байна.	
		Хэрэгжилт 40 хувь					

БИЕЛЭЛТИЙН ТОВЧОО

Д/Д	**Арга хэмжээний тоо**	**Үүнээс**				**Үнэлэх боломжгүй**	**БИЕЛЭЛТИЙН ДҮН /хувь/**
		Биелсэн /100/	**Хэрэгжих шатандаа**		**0%**		
			70%	**40%**			
1	129	13	36	62	8	10	**52.9**

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР